



Нэгдсэн Үндэстний
Байгууллага
МОНГОЛ УЛС



Монгол Улс дахь НҮБ-ын ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН 2024




Агуулга

Өмнөх үг	3
НҮБ-ын Удирдлагын баг	4
НҮБ-ын хөгжлийн системийн гол түншлэгч байгууллагууд	5
Бүлэг 1: Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдал	6
Бүлэг 2: Үндэсний хөгжлийн тэргүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэхэд НҮБ-ын хөгжлийн системээс үзүүлж буй дэмжлэг	10
2.1 НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ (ТХХАХ)-ний хэрэгжилт	11
2.2 НҮБ-ын ТХХАХ-ний Тэргүүлэх чиглэл, үр дүнгийн зорилт, үр дүн	13
Стратегийн тэргүүлэх чиглэл 1: Хүний хөгжил, сайн сайхан байдал	13
Стратегийн тэргүүлэх чиглэл 2: Ногоон, хүртээмжтэй, тогтвортой өсөлт	23
Стратегийн тэргүүлэх чиглэл 3: Хүн төвтэй засаглал, эрх зүйт ёс, хүний эрх	34
2.3 Түншлэл, Тогтвортой хөгжил 2030 хөтөлбөрийн санхүүжилтийг дэмжих	41
2.4 НҮБ-ын нэгдмэл хамтын ажиллагааны үр дүн: НҮБ-ын үйл ажиллагааны харилцан уялдаа, үр дүн, нөлөө	44
2.5 Үнэлгээ, сургамж	45
2.6 Санхүүжилт, хөрөнгийн татан төвлөрүүлэлт	46
Бүлэг 3: НҮБ-ын Удирдлагын багаас 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүд	47
Товчилсон үгийн тайлбар	51

Өмнөх үг

2024 он бол Нэгдсэн Үндэстний Байгууллага болон Монгол Улсын хамтын ажиллагаа өргөжин тэлсэн бас нэгэн чухал жил байлаа. Монгол Улсын Засгийн газар, иргэний нийгэм, олон улсын түнш байгууллагуудтай нягт хамтран ажилласнаар бид тогтвортой хөгжлийн төлөө дорвитой ахиц дэвшил гаргаж, аливаа эрсдэлийг сөрөн тэсвэрлэх чадавхыг улс орон даяар бэхжүүлж, хэнийг ч орхигдуулахгүйгээр хөгжих нийтлэг зорилгодоо тууштай байгаагаа дахин нотолсон юм.

Монгол Улс нь дэлхий дахины хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох өргөн хүрээтэй зөвлөлдөх уулзалтуудад оролцох замаар Ирээдүйн төлөөх гэрээ байгуулах үйл хэрэгт идэвхтэй оролцсон. НҮБ нь Монгол Улсын Гадаад харилцааны яамтай хамтран Дэлхийн эмэгтэйчүүдийн чуулга уулзалтыг 2024 оны наймдугаар сард Монгол Улсад зохион байгуулсан нь жендэрийн эрх тэгш байдал, оролцоог хангасан бодлого шийдвэр гаргахын төлөө тууштай хамтран ажиллаж байгаагаа дахин нотолсон хэрэг юм. Тус чуулга уулзалтад НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч, хатагтай Амина Ж.Мохаммед оролцсон нь Монгол Улсад төдийгүй дэлхий дахинаа өрнөж буй эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх асуудлаарх яриа хэлэлцүүлэгт хүчтэй түлхэц болсон юм. НҮБ анх үүсэн байгуулагдсан түүхэн тэмдэглэлт өдөр Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ Монгол дахь НҮБ-ын байранд зочилсон нь Тогтвортой хөгжлийн зорилгуудыг хэрэгжүүлэхийн төлөө Монгол Улс болон НҮБ-ын тууштай хамтын ажиллагааны тод илэрхийлэл болсон.



Яап ван Хиерден
Монгол Улс дахь НҮБ-ын
Суурин зохицуулагч

Гэхдээ 2024 онд томоохон бэрхшээл сорилтууд мөн тулгарсныг дурдах нь зүйтэй. 2023-2024 оны өвөл тохиосон зудын гамшиг бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг олон мянган малчин өрхөд хүндээр тусч, уур амьсгалын өөрчлөлтийн хавсарсан цочролыг даван туулах Монгол Улсын чадавхыг сорьсон. НҮБ-ын Хүмүүнлэгийн тусламжийн баг нь Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газартай хамтран шуурхай ажиллаж 66,685 малчдад нэн шаардлагатай тусламж үзүүлсэн. Яаралтай мөнгөн тусламжийн хөтөлбөрт эмзэг бүлгийн 2000 гаруй өрх хамрагдаж, малын дархлаажуулалтын аяны хүрээнд 3.3 сая толгой малыг хамгааллаа. Үүний зэрэгцээ хүнс тэжээлийн зорилтот хөтөлбөр хэрэгжүүлж 10 мянга гаруй жирэмсэн эмэгтэйчүүд, хүүхэд, хөхүүл эхчүүдэд дэмжлэг үзүүлсэн. Эдгээр хүчин чармайлт нь хүний амь насыг аврахаас гадна бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн юм.

Монгол Улсын ирээдүйн талаарх нэгдсэн төсөөлөл, нягт хамтын ажиллагаа байхгүй бол эдгээр ахиц дэвшилд хүрэх боломжгүй байв. Цаашид ч, НҮБ нь Монгол Улсад илүү хүртээмжтэй, эрсдэлийг сөрөн тэсвэрлэх чадавхтай, тогтвортой нийгмийг бий болгоход дэмжлэг үзүүлсээр байх болно. Монгол Улсын Засгийн газар, хамтрагч түнш байгууллагууд болон хамтран ажиллаж буй бүх талуудад НҮБ гүн талархал илэрхийлж байна. Бид хамтдаа, 2030 оны Тогтвортой хөгжлийн хөтөлбөр, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 2050-ыг амжилттай хэрэгжүүлэхийн төлөө тууштай хамтран ажиллах болно.

НҮБ-ын Удирдлагын баг



Яап ван Хьерден

Нэгдсэн Үндэстний
Байгууллага
Монгол Улс дахь НҮБ-ын
Суурин зохицуулагч



Винод Ахужа

ХХААБ
Суурин төлөөлөгч



Жин Пактуран

ХААХС
Пакистан, Иран, Монгол
Улсыг хариуцсан захирал



Чанхи Ли

ОУХБ
БНХАУ, Монгол Улсыг
хариуцсан Товчооны захирал



Даниел Квеку Сэм

ОУШХБ
Монгол Улсыг хариуцсан
захирлыг түр орлон
гүйцэтгэгч



Сильви Кочин

ОУХТ
Ази, Номхон Далайн бүс
хариуцсан захирал



Ацуко Окуда

ОУЦХБ
Ази, Номхон далайн бүс нутаг
хариуцсан захирал



Рори Мунговен

ХЭДКГ
Ази, Номхон далайн бүсийн
газрын тэргүүн



Имони Мерфи

НҮБ-ДОХ-той тэмцэх Нэгдсэн
хөтөлбөр
Ази, Номхон далайн бүсийн
төвийн захирал



Жиан-Филипп Роде

НҮБ-ын ХХБХ
Техникийн хамтын
ажиллагааны хөтөлбөрийн
мэргэжилтэн



Матильда Димовска

НҮБХХ
Суурин төлөөлөгч



Марко Тосано Ривалта

НҮБ-ын ГЭБГ
Ази, номхон далайн бүсийн
төвийн захирал



Юужон Ким

НҮБ-ын БОХ
Хөтөлбөрийн удирдлагын
албаны Ахлах мэргэжилтэн



Баасанжавын Ганболд

НҮБ-ын АНДЭЗНК
Зүүн-Хойд Азийн бүсийн
төвийн Тэргүүн



Шахбаз Хан

НҮБ-ын БШУСБ
НҮБ БШУСБ-ын Бээжин дэх
төлөөлөгчийн газрын захирал,
БНАСАУ, Япон, Монгол, БНХАУ,
БНСУ-ыг хариуцсан Төлөөлөгч



Халид Шарифи

НҮБ-ын ХАС
Тэргүүн



Казуко Ишигаки

НҮБ-ын ХАБИТАТ
Ази Номхон Далайн бүсийн
захирал



Эваристе Коуасси-Комлан

НҮБ-ын ХС
Суурин төлөөлөгч



Стефен Б. Каргбо

НҮБ-ын АУХБ
Бээжин дэх БНХАУ, БНАСАУ, Монгол
Улс хариуцсан төлөөлөгч, Бүсийн
төлөөлөгчийн газрын тэргүүн



Бенедикт Хофманн

НҮБ-ын МБГХТГ
Зүүн Өмнөд Ази Номхон
далайн бүсийн төвийн
захирал



Самина Кадвани

НҮБ-ын ТҮА
Улс орнууд хариуцсан газрын
захирал



Кристиан Хайнэл

НҮБ-ын СДХ
Ази, Номхон далайн бүс
хариуцсан менежер



Кристин Араб

НҮБ-Эмэгтэйчүүд
Ази, Номхон далайн бүс
хариуцсан захирал



Сокорро Эскаланте

ДЭМБ
Суурин төлөөлөгч



Шериф Месиша

НҮБ-ын АБА
Бүс нутгийн аюулгүй
байдлын зөвлөх



Хай Кюун Жүн


НҮБ-ын ДАЭДК
Ази, Номхон далайн бүсийн
төвийн захирал

НҮБ-ын хөгжлийн системийн гол түншлэгч байгууллагууд

Олон талт санхүүжилтийн түншүүд



Хоёр талт санхүүжилтийн түншүүд



Хувийн хэвшил



Бүлэг 1: Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдал



Тэмээчин охид,
©ОУШХБ 2024 /С.Тамир

Монгол Улс дахь НҮБ

Монгол Улс 2023 оны эдийн засгийн өсөлтийн эрчээ 2024 онд мөн хадгалан үргэлжлүүлж, илүү ахицтай ажиллалаа. Монгол Улсын эдийн засаг 2024 онд 4.9 хувийн өсөлт үзүүлэхэд уул уурхайн олборлох салбарын экспорт голлон (93 хувь) нөлөөлсөн бөгөөд үүний зонхилох хэсэг буюу 91.4 хувийг зөвхөн нэг улсын зах зээлд гаргажээ. Энэ нь тус улсын эдийн засгийг нэн яаралтай төрөлжүүлэх нь хөгжлийн тэргүүлэх зорилт хэвээр байгааг илэрхийлж байна.

Монгол Улсын хүн амын хөдөлмөрийн оролцооны түвшин 62.2 хувь, үүнд эрэгтэйчүүдийнх 71.4 хувь, эмэгтэйчүүдийнх 53.7 хувь байна. Нийт хөдөлмөр эрхэлж буй хүн амын 46 орчим хувь нь албан бус хөдөлмөр эрхэлж байна. Хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад ажиллах хүчний ур чадвар нийцэхгүй байх, хөдөлмөрийн бүтээмж муу байх зэрэг нь Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн гол сорилт болж байгаагийн зэрэгцээ ажилчид тогтвор суурьшилгүй байх, цалин хөлс бага байх нөхцөлд хүргэж байна.



Монгол Улс жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж, эдийн засгаа төрөлжүүлэхийг зорьж байна. Зураг дээр: Ноос, ноолуурын үйлдвэрийн ажилтнууд. ©НҮБСЗГ

Монгол Улсын эрчим хүчний систем нь өөрийн орны байгалийн арвин нөөц болох чулуун нүүрсний үйлдвэрлэлд түшиглэдэг. Үүний уршгаар байгаль орчинд учрах сөрөг үр дагавар үлэмж бөгөөд Монгол орон уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд өртөх эрсдэлийг улам нэмэгдүүлж байна. Засгийн газраас 2024 оны арваннэгдүгээр сард цахилгаан эрчим хүчний үнэ тарифыг нэмэгдүүлсэн. Сэргээгдэх эрчим хүч рүү шилжсэнээр тус улс ногоон хийгээд илүү төрөлжсөн эдийн засгийн загвараар хөгжих боломж бүрдэнэ. Ойролцоогоор нийт өрхийн 4.78 хувь нь хүнсний аюулгүй байдал нь алдагдах дунд болон хүнд нөхцөлд амьдарч байна. Үүний зэрэгцээ Монгол Улс хүнсний импортоос ихээхэн хамааралтай бөгөөд ялангуяа, тахиа, шувууны махны импортын хамаарал илүү өндөр байна.

Монгол Улсад сүүлийн жилүүдэд цахим гэмт хэрэг, хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчил, авлигын хэргийн тохиолдол нэмэгдэж байна. Монгол Улс авлигын төсөөллийн индексээр 180 орноос 114 дүгээрт жагссан. Монгол Улсын Хүний хөгжлийн индекс (ХХИ) 2022 онд 0.741 болж дэлхийн 193 орноос 96-д эрэмбэлэгдсэн. Цахим засаглалын хөгжлийн индекс (ЦЗХИ)-ээр 2022 онд дэлхийн 193 орноос 74-т

жагсаж байсан Монгол Улс 2024 онд 46-д эрэмбэлэгдэж мэдэгдэхүйц урагшилсан байна. Монгол Улс нь боловсролын салбарын бүх түвшин, төрөл хэлбэрийг хамарсан томоохон шинэчлэлийг хэрэгжүүлж байна. Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт орсноор сургалтын үндсэн гадаад хэл нь англи хэл байх заалтыг тусгаж 2024 оны долдугаар сараас эхлэн мөрдөж байна. Агаарын чанар, хог хаягдлын менежмент, хөдөө аж ахуй, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг сааруулах зэрэг салбарт томоохон сорилт тулгарч байгаагаар 2024 оны Байгаль орчны гүйцэтгэлийн индексийн тайланд Монгол Улс 37.2 оноо авч 143 дугаарт жагссан байна. Дэлхийн банкны тайланд Монгол Улс уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх болон хөгжлийн зорилтуудаа хэрэгжүүлэхийн тулд ойрын 25 жилд 10 гаруй тэрбум ам.долларын нэмэлт хөрөнгө оруулалт шаардлагатай хэмээн тэмдэглэжээ.

Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэйгээр зудын давтамж нэмэгдэх болсон нь хүн амын амьжиргаа, байгаль орчны экосистемд олон талын сөрөг нөлөө үзүүлж байна. Зудын уршгаар малын тоо толгой олон тоогоор хорогдож, малчдад эдийн засгийн ихээхэн дарамт учруулж, малаа алдсан малчид хот суурин бараадан нүүдэллэхэд хүргэж

болзошгүй. Зудын аюул нь зөвхөн мал сүрэг төдийгүй зэрлэг ан амьтан, биологийн олон янз байдалд аюул учруулж экосистемийн нарийн тэнцвэрт байдал алдагдахад хүргэнэ. Түүнчлэн зудын үеэр хорогдсон олон мянган тоо толгой мал, амьтдын сэг зэм задралд орж хөрс, ус бохирдох эрсдэлийг нэмэгдүүлнэ. Монголд 2023-2024 оны өвөл зуд нүүрлэж, бэлчээрийн мал аж ахуйд түшиглэсэн малчдын амьдралд хүндээр туссан. Зудын уршгаар нийгэм, эдийн засгийн ихээхэн гарз хохирол амссан. Нийт 8.1 сая толгой

мал хорогдож, хөдөө аж ахуйн салбарын ДНБ 27 хувиар буурсан төдийгүй гамшигт нэрвэгдсэн малчин өрхийн нэг гишүүнд ногдох цэвэр орлого 12-20 хувиар буурсан. Монгол оронд зудын давтамж, ноцтой байдал нэмэгдэж байгаа энэ нөхцөлд газар зохион байгуулалтын тогтвортой менежмент, арга барилыг цаг алдалгүй хэрэгжүүлэх, цаашид тохиож болзошгүй гамшгийн нөлөөллийг сөрөн тэсвэрлэх чадавх, бэлэн байдлыг сайжруулах зайлшгүй шаардлага байна.

Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 90 орчим хувь нь зуд болох 'өндөр' болон 'дунд' зэргийн эрсдэлтэй байна. Ийм тохиолдолд агаарын температур -40 хэм хүрч хүйтрэх, мөстөх учир мал сүргийг бэлчээрт гаргах боломж хязгаарлагдана.
©А.Сэргэлэн / ОУШХБ



Монгол Улсын 2024 оны УИХ-ын ээлжит сонгуульд олон нам амжилттай оролцож, иргэдийн төлөөллийг илүү олон талт болгох зорилго биеллээ олсон. Шинээр бүрдсэн УИХ нь хүн амын бүлгүүдийн олон төлөөллийг бүрдүүлсэн бөгөөд тэдгээрийн 60 хувь нь анх удаа сонгогдсон гишүүд байна. Казах үндэстний төлөөллийн тоо тав болж нэмэгдэв. Гадаад улсад амьдарч байгаа иргэдийн сонгуулийн оролцоо ч сайжирсан. Эвслийн Засгийн газар байгуулахаар Монгол Ардын нам (МАН), Ардчилсан нам (АН), ХҮН нам хамтын ажиллагааны санамж бичигт 2024 оны долдугаар сард гарын үсэг зурсан. Гурван намын хамтран баталсан Эвслийн гэрээний дагуу Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулсан. Үйл ажиллагааны хөтөлбөрт бүс нутгийн хөгжлийн бодлого, хүний

хөгжлийн бодлого, эдийн засгийн бодлого, хүний эрхэд суурилсан засаглалын бодлого гэсэн бодлогын үндсэн дөрвөн чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх 619 арга хэмжээ тусгагдсан. Монгол Улсын хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг арилгах зорилгоор 2024 оныг "Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил" болгон зарласан. Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан мал аж ахуйн салбарт үүсэж болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, мал аж ахуйн үйлдвэрлэл, малчдын хоршоог дэмжих замаар тогтвортой хөгжүүлэх зорилго бүхий Шинэ сэргэлтийн бодлогын Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хүрээнд "Шинэ хоршоо-чинээлэг малчид" санаачилгыг хэрэгжүүлж эхэлсэн. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас 2025 оныг Нийслэл Улаанбаатар хотын бүтээн байгуулалтыг дэмжих жил болгон зарласан.



Монгол Улсын Их хурлын эмэгтэй гишүүд, 2024 ©НҮБХХ

Монгол Улсын хувьд жендэрийн ялгаатай байдал эрэгтэйчүүдийн хувьд өвөрмөц ажиглагдаж байна. Төрөх үеэс нь тооцсон эрэгтэйчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдийнхээс дунджаар 9.4 жилээр богино байна. Хөдөө орон нутгийн эрчүүд, хөвгүүдийн боловсролын түвшин эмэгтэйчүүд, охидтой харьцуулахад доогуур байгаагийн зэрэгцээ эмэгтэйчүүд нь илүүтэй дээд боловсрол эзэмшиж байна. Эхчүүдэд зориулсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, гэр бүл төлөвлөлт, үр хөндөлтийн аюулгүй үйлчилгээнд хөдөө орон нутгийн эмэгтэйчүүд, охид хамрагдахад багагүй бэрхшээл тулгарч байна. Монголын залуучуудад цахим хөгжлийн ялгаа, сэтгэцийн эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, ур чадварын зөрүү, улс төрийн болон иргэний оролцоо, бүс нутгийн ялгаатай байдал зэрэг цөөнгүй сорилт бэрхшээл тулгарч байна. Монгол Улс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгох, сонгогдох эрхийг баталгаажуулсан улс юм. 2024 оны нэгдүгээр сараас хэрэгжиж эхэлсэн Улс төрийн намуудын тухай хуульд эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг улс төрийн сонгуульд нэр дэвшүүлсэн улс

төрийн намуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх заалт тусгагдсан бөгөөд 2024 онд анх удаа намын жагсаалтаар хөгжлийн бэрхшээлтэй хоёр иргэн УИХ-ын гишүүнээр сонгогдсон. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор, 2023 онд Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, төрийн захиргааны хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчдад тавигдах албан шаардлагыг хөнгөрүүлсэн. Гэсэн хэдий ч Монголын нийгмийн орчинд хөгжлийн бэрхшээлтэй иргэд хамгийн тусгаарлагдсан нийгмийн бүлэг хэвээр байна. АТэдний ажил хөдөлмөр хийх, нийгмийн харилцаанд оролцох боломж хязгаарлагдмал хэвээр, бие даан амьдрах чадварт нь тулгарч буй олон бэрхшээл байна. Монгол Улсын 210 мянга гаруй иргэн гадаад улс оронд амьдарч байгаа гэсэн тооцоо бий. Гадаадад амьдарч буй монголчууд цагаачлалын статус, соёлын ялгаа, хүлээн авагч орондоо нийгэмших нарийн төвөгтэй байдал зэргээс шалтгаалан нийгэм, эдийн засгийн олон сорилт бэрхшээлтэй тулгарч байна.

Үндсэн үзүүлэлтүүд



ДНБ-ний өсөлт¹
2024

4.9%



Инфляцийн
түвшин²
2024 оны 12-р сар

9



Хүн ам³
2024

3.546 сая



1000 хүн амд
ногдох төрөлтийн
түвшин
2024

17



Ядуурлын түвшин⁴
2022

27.1%



Жендэрийн тэгш
бус байдлын
индекс⁵
2022

0.297

нийт 193 орноос 72-т



ХХИ⁶
2022

0.741

нийт 193 орноос 96-д



ЦЗХИ⁷
2024

0.8457

нийт 193 орноос 46-д



Эрх зүйт ёс индекс⁸
2024

0.53

нийт 142 орноос 66-д



Авлигын
төсөөллийн индекс⁹
2024

33

нийт 180 орноос 114-т



Хөдөлмөр эрхэлж буй
нэг хүнд ногдох бодит
ДНБ-ий жилийн дундаж
өсөлт¹⁰
2024

0.8%



Эхийн эндэгдэл
(100,000 амьд
төрөлтөд ногдох)¹¹
2024

22.5



5 хүртэлх насны
хүүхдийн эндэгдэл (1000
амьд төрөлтөд ногдох)¹²
2024

15



Ажилгүйдлийн
түвшин¹³
2024 оны 4-р улирал

5.3%



Дэлхийн хэвлэлийн
эрх чөлөөний
индекс¹⁴

109

нийт 180 орноос

1. www.1212.mn/en/dissemination/92900540

2. www.1212.mn/en/dissemination/92900544

3. www.1212.mn/en/dissemination/93289600

4. 1212.mn/en/statistic/statcate/573066/table-view/DT_NSQ_1900_007V12

5. hdr.undp.org/data-center/thematic-composite-indices/gender-inequality-index#/indicies/GII

6. hdr.undp.org/data-center/specific-country-data#/countries/MNG

7. publicadministration.un.org/egovkb/en-us/Data/Country-Information/id/113-Mongolia

8. worldjusticeproject.org/rule-of-law-index/country/2024/Mongolia/

9. www.transparency.org/en/cpi/2024/index/mng

10. www.1212.mn/en/dissemination/93498258

11. hdc.gov.mn/media/uploads/2025_01/b9acf523cbd34cbfa6b6f54ec18fa7a6.pdf

12. www.1212.mn/en/dissemination/93626138

13. www.1212.mn/en/dissemination/97783262

14. rsf.org/en/2024-world-press-freedom-index-journalism-under-political-pressure

Бүлэг 2: Үндэсний хөгжлийн тэргүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэхэд НҮБ-ын хөгжлийн системээс үзүүлж буй дэмжлэг



2.1 НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ (ТХХАХ)-ний хэрэгжилт

2023-2027 онд хэрэгжүүлэх Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ (НҮБ-ын ТХХАХ) баримт бичгийг хэрэгжүүлж эхлээд хоёр дахь жилийн нүүрийг үзэж байна. Энэ хугацаанд Монгол Улс дахь НҮБ-ын Удирдлагын баг (UNCT) нь тус улсын үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлийн зорилтууд, ТХЗ-уудын хэрэгжилтийг хурдасгахад чиглэсэн дэмжлэгийн хүчин чармайлтаа үргэлжлүүлээ.

Монгол Улс дахь НҮБ нь 2024 онд хүний хөгжил, эдийн засгийн өсөлт, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх үйл ажиллагаа, засаглалын шинэчлэл зэрэг Монгол Улсад ТХЗ-уудын хэрэгжилтийг дэмжих чиглэлээр томоохон ахиц дэвшил гаргасан.

2024 оны гол амжилт



Хүмүүсийг чадавхжуулах, Хүний сайн сайхны төлөө

Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулахад дэмжлэг үзүүлж, эмзэг бүлгийн 500 мянга гаруй хүнд хүрч үйлчилсэн. Эхийн эндэгдэл 3.9 хувиар буурч, 200 мянга гаруй хүн ундны усны сайжруулсан эх үүсвэртэй болсон.



Хүртээмжтэй эдийн засгийг идэвхжүүлэх

Цахим хөгжил, ногоон санхүүжилт, залуучуудын хөгжлийг дэмжиж, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлсэн. 2023 онд Монгол Улсын ДНБ 70.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх онохоос 30.8 хувиар өсчээ.



Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх үйл ажиллагааг идэвхжүүлэх

33 сая гаруй га нутаг дэвсгэрийн тогтвортой менежментийг хэрэгжүүлж, 49 мянган га доройтсон бэлчээр нутгийг сэргээж, 82 мянган га талбайд бэлчээрийн тогтвортой менежментийн арга туршлагыг нэвтрүүлж, долоон аймгийн нутаг дэвсгэрт 320 мянган га заган ойг сэргээх ажлыг тус тус хийсэн.



Институцийг бэхжүүлэх

УИХ дахь эмэгтэй гишүүдийн төлөөлөл 25.4 хувьд хүрч нэмэгдсэн, авлигатай тэмцэх ажлыг эрчимжүүлж, ил тод, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэхийн тулд цахим засаглалын шинэчлэл ахицтай урагшилж байна.

Дараагийн бүлгүүдэд зорилтот үр дүн тус бүрийн тодорхой ололт амжилт, нөлөөллийн жишээний хамтаар дэлгэрэнгүй мэдээлнэ

Монгол Улсын Цахим хөгжлийн үсрэлт: Цахим засаглалын хөгжлийн индексээр 2022 онд дэлхийн 193 орноос 74-р байрт байсан Монгол Улс 2024 онд 46-д эрэмблэгдсэн ©НҮБХС





1. Ядуурлыг устгах
\$971,683 | 2.1%



2. Өлсгөлөнг устгах
\$2,495,269 | 5.4%



3. Эрүүл мэндийг дэмжих
\$9,682,828 | 21.0%



4. Чанартай боловсролыг дэмжих
\$1,961,004 | 4.3%



5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах
\$2,698,942 | 5.9%



6. Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах
\$1,629,562 | 3.5%



7. Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх
\$821,501 | 1.8%



8. Эдийн засгийн өсөлт, зохистой хөдөлмөрийг дэмжих
\$3,318,252 | 7.2%



9. Аж үйлдвэр, инновац, дэд бүтцийг хөгжүүлэх
\$3,803,382 | 8.3%



10. Тэгш бус байдлыг бууруулах
\$322,486 | 0.7%



11. Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих
\$1,153,799 | 2.5%



12. Хариуцлагатай үйлдвэрлэл, хэрэглээг дэмжих
\$67,180 | 0.1%



13. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах
\$10,768,794 | 23.4%



15. Хуурай газрын эко системийг хамгаалах
\$2,721,146 | 5.9%



16. Энх тайван, шударга ёсыг цогцлоох
\$2,031,021 | 4.4%



17. Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх
\$1,653,277 | 3.6%

2.2 НҮБ-ын ТХХАХ-ний Тэргүүлэх чиглэл, үр дүнгийн зорилт, үр дүн



©НҮБ-ын Хүн амын сан

Стратегийн тэргүүлэх чиглэл 1: Хүний хөгжил, сайн сайхан байдал



Үр дүнгийн зорилт 1:

2027 он гэхэд хот, хөдөөгийн хүн бүр, ялангуяа нэн эмзэг болон орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүд нь өөрсдийн нөөц боломжийг бүрэн дүүрэн эрх тэгш ашиглаж, хүний эрхэд суурилсан, хүртээмжтэй, жендэрийн мэдрэмжтэй, хямрал цочролд тэсвэртэй эрүүл мэнд, хоол тэжээл, боловсрол, нийгмийн хамгаалал, ус, ариун цэврийн байгууламжийн болоод бусад үйлчилгээний үр шимийг хүртэнэ.

Монгол Улс дахь НҮБ нь 2024 онд тус улсын нийт иргэд, ялангуяа эмзэг бүлгийнхэн өөрсдийн чадавхыг бүрэн дүүрэн ашиглах, нийгмийн суурь үйлчилгээнд тэдний хамрагдах боломжийг бүрдүүлэх чиглэлд ахиц дэвшил гаргасан. Эхийн эндэгдэл 3.9 хувиар буурч, нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийг өргөжүүлэн эмзэг бүлгийн өрх, хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдэд хүрч үйлчилсэн нь бодит ахиц юм. Түүнчлэн Нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээний тухай шинэ хуулийг боловсруулснаар гамшгаас сэргийлэх урт хугацааны бэлэн байдлыг хангах эрх зүйн орчин бүрдсэн.

‘Girls Code’ хөтөлбөр, дижитал сургалтын агуулгыг хөгжүүлэх зэрэг санаачилгууд нь охид, хөдөө орон нутгийн иргэдэд илүү ашиг тусаа өгч боловсролын үр дүнгийн зорилтыг хэрэгжүүлэхэд түлхэц болж байна. Түүнчлэн, хоол тэжээлийн дутагдлаас урьдчилан сэргийлэх, эмчлэх, эрүүл хооллолтыг дэмжихэд чиглэсэн хоол тэжээлийн хөтөлбөрүүдэд 344,100 гаруй хүн хамрагдав. НҮБ нь эх, нярайн эндэгдэлээс сэргийлэх, тандан судлах, хариу арга хэмжээ

авах, эх барихын үйлчилгээ, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангах зэрэг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний салбарт үндэсний чадавхыг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Гэвч хүнсний аюулгүй байдлын асуудал, ялангуяа эмзэг бүлгийн хүн амын дунд түгшүүртэй хэвээр байна. Зудтай өвлийн онцгой байдал нь аливаа хямралыг сөрөн тэсвэрлэх чадавх, бэлэн байдлыг сайжруулах нь онцгой чухал болохыг харуулсан. Хүний хөхөнцөр вирусийн (ХХВ) эсрэг дархлаажуулалтад хамрагдалтын түвшин 25 хувьд хүрсэн хэдий ч хамрагдвал зохих насны охид, хөвгүүдийн нэлээд хэсэг нь хамгаалалтгүй хэвээр байгаа нь дархлаажуулалтын хамрах хүрээг өргөжүүлэх хүчин чармайлтаа цааш үргэлжлүүлэх шаардлагатайг илэрхийлж байна. Эдгээр сорилтыг шийдвэрлэх, ахиц дэвшлийг хурдасгах, хэнийг ч орхигдуулахгүйн тулд НҮБ нь засгийн газар болон бусад түншүүдтэйгээ үргэлжлүүлэн хамтран ажиллах болно.



Жендэрийн мэдрэмжтэй, цочролд тэсвэртэй, хямд төсөр, чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээ (бие махбодийн, сэтгэцийн, бэлгийн болон нөхөн үржихүйн), хоол тэжээлийн болон ус ариун цэврийн байгууламжийн үйлчилгээг хүн бүрт хүргэх эрүүл мэндийн нэгдсэн тогтолцоог дэмжих чадавх бэхжсэн байна.

Алслагдсан бүсэд эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжтэй болгох нь



74

Эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээний төвийг дэмжив.



165

эмчийг сургалтад хамруулав.

Монгол Улсад эрсдэлийг сөрөн тэсвэрлэх чадвартай, хүртээмжтэй, тэгш шударга эрүүл мэндийн тогтолцоог хөгжүүлэхэд НҮБ ихээхэн дэмжлэг үзүүлж байна. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний 74 төвийг явуулын эмнэлгийн иж бүрдлээр тоноглож, алслагдсан бүс нутаг, ялангуяа зудын хүнд нөхцөлд хүн амд хүрч үйлчлэх нөхцөлийг бүрдүүлж, сум, баг, өрхийн нийт 165 эмчийг сургалтад хамруулсан зэрэг нь онцлох амжилт юм.

НҮБ-аас Монгол Улсын Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хуулийг шинээр боловсруулж, батлахад дэмжлэг үзүүлж онцгой байдлын үед бэлэн байдлыг дээшлүүлэх, нийгмийн эрүүл мэндийн санхүүжилтийг нэмэгдүүлэх, Өвчний хяналт, урьдчилан сэргийлэх үндэсний төвүүдийг байгуулах, нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан. Түүнчлэн Томуутай тэмцэх хамтын ажиллагааны хүрээнд томуу, томуу төст өвчний талаарх урьдчилсан мэдээг сайжруулах, Хамтарсан хөндлөнгийн үнэлгээ хийх, яаралтай тусламжийн бэлэн байдлыг сайжруулах зорилгоор Эрүүл мэндийн аюулгүй байдлын үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах чиглэлээр Монгол Улсад дэмжлэг үзүүлсэн.

НҮБ нь талуудыг удирдан чиглүүлэх, салбар хоорондын хэлэлцүүлэг өрнүүлэх, өргөн цар хүрээг хамарсан дүн шинжилгээ хийх зэрэг чиглэлд дэмжлэг үзүүлж Цахим эрүүл мэндийн стратегийн төслийг боловсруулахад хувь нэмэр оруулсан. НҮБ нь 2024 онд Эрүүл мэнд, Цахим хөгжлийн яамдтай хамтран, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын удирдлага дор eKid аппликейшн болон Эх, хүүхдийн эрүүл мэндийн цахим дэвтэр, Жирэмсний хяналтын карт зэрэг эрүүл мэндийн долоон програм бүхий eMongolia 4.0 хувилбарыг хэрэглээнд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэв. Түүнчлэн Нийгмийн эрүүл

мэндийн төвүүд, сургуулиудын түвшинд пульсоксиметр, ХХВ-ийн дархлаажуулалт зэрэг шинэ төрлийн үзлэг, эрүүл мэндийг дэмжих үйлчилгээний хууль эрх зүй, бодлого, төсвийн хүрээг цогц уялдаатай хөгжүүлэх нөхцөл бүрдсэн.

Өсвөр насныхан болон эхийн эрүүл мэндэд анхаарал хандуулж, НҮБ нь залуучуудад ээлтэй үйлчилгээг Нийгмийн эрүүл мэндийн төвүүд, ХХВ-ийн дархлаажуулалтын сурталчилгаа, сургуулийн эрүүл мэндийн үнэлгээ зэрэгт тусгаж уялдуулах ажлыг дэмжиж ирсэн. Жирэмслэлтээс хамгаалах хэрэгслийн хүртээмж, эх, нярайн асаргаа сувилгаа, Жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг хариу арга хэмжээг сайжруулах, эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрт жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх агуулгыг тусгах зорилго бүхий Бодлого, үйл ажиллагааны стандарт журам (SOPs) боловсруулсан.

Нэн шаардлагатай үйлчилгээг бэхжүүлэхийн тулд НҮБ-ын зүгээс долоон амаржих газарт эх, нярайн эндэгдлээс сэргийлэх тандалтыг сайжруулах, 164 эх баригчийг сургалтад хамруулж, онцгой байдлын үед ажиллах Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн Сургагч багш бэлтгэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэрэгт дэмжлэг үзүүлээ.

НҮБ болон Люксембургийн Их Гүнт улсын дэмжлэгтэйгээр зүрхний төрөлхийн эмгэгтэй хүүхдэд зүрхний нээлттэй мэс засал хийх аргыг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд нутагшуулж, үндэсний мэргэжилтнүүд ийм төрлийн мэс заслыг бие даан хийх чадавх бүрдсэн. Үүний үр дүнд 2024 онд нийт 26 хүүхдэд мэс засал хийжээ. Түүнчлэн Монгол Улсад зохион байгуулсан ХХВ-ийн эсрэг дархлаажуулалтын аянд 460 гаруй эмнэлгийн мэргэжилтэн оролцож зорилтот хүн амын бүлгийн 25 хувийг хамруулсан байна.



Үндэсний хэмжээнд Хүний хөхөнцөр вирусийн эсрэг дархлаажуулалтын аяныг явуулж зорилтот бүлгийн хүн амд хүрч үйлчиллээ. ©ДЭМБ

Дархлаажуулалтын үйлчилгээнд хийсэн жендэрийн цогц шинжилгээний үр дүнд суурилан жендэрийн мэдрэмжтэй сургалтын хөтөлбөр боловсруулж, үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан сургалтыг зохион байгуулсан. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэгжийн хүчин чадлыг сайжруулах зорилгоор алслагдсан эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний 10 нэгжийг нарны зай хураагуураар тоноглож, улсын 5 эмнэлэгт хүчилтөрөгч өтгөрүүлэгч төхөөрөмж суурилуулснаар хүний амь нас аврах тусламж үйлчилгээний хүртээмж сайжирсан.

Түүнчлэн эхийн эндэгдэл, эх барихын тусламж үйлчилгээ, кесар хагалгааны чиг хандлага, бэлгийн болоод нөхөн үржихүйн яаралтай тусламжийн талаарх судалгааны ажлыг дэмжихэд тодорхой хувь нэмэр оруулсан. Монгол Улсын хүн ам насжиж байгаатай холбогдуулан, ахмад настны асаргаа сувилгааны удирдамж боловсруулах, Эрүүл насжилтыг дэмжих үйл ажиллагааны хөтөлбөр (2025-2028), Ахмад настны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, цаашлаад эрүүл мэндийн үйлчилгээг хүн бүрт тэгш хүргэх зэрэгт чиглэсэн техникийн туслалцааг НҮБ-аас үзүүлсэн.



Үндэсний хэмжээнд Хүний хөхөнцөр вирусийн эсрэг дархлаажуулалтын аяныг явуулж зорилтот бүлгийн хүн амд хүрч үйлчиллээ. ©ДЭМБ

Боловсролын тогтолцоо бүхэлдээ, боловсролын байгууллагууд нь нийт хүүхэд, залуучууд, тэр дундаа эмзэг бүлгийн хүүхэд, залуучуудыг бага насны хүүхдийн боловсрол, амьдрах ухаан, бэлгийн цогц боловсрол зэрэг боловсролын бүхий л үйлчилгээнд ялангуяа онцгой байдлын үед хүртээмжтэй, тэгш хамруулан сургах, сургуулиас хөдөлмөрийн зах зээлд төвөггүй шилжих боломжийг бүрдүүлэх хэмжээнд хүрч чадавхжсан байна.

Цахим хуваагдлыг арилгахад дэмжлэг үзүүлсэн нь:



30

охид Girls Code хөтөлбөрт хамрагдав.



25

математикийн интерактив модуль сургалт



312,000

хандалттай



70,000

хэрэглэгчтэй болсон



1300

багш нар цахим сургалтад хамрагдсан



54,000

хүн цахим ур чадварын сургалтад хамрагдсан.

Цахим хөгжлийн ялгааг арилгахын тулд 'Girls Code' хөтөлбөрийг НҮБ-аас дэмжиж, хөгжлийн бэрхшээлтэй 30 охидыг цахим ур чадвар эзэмших сургалтад хамруулсан. Түүнчлэн 1-2-р ангийн сурагчдад зориулсан математикийн 25 интерактив модуль сургалтыг Medle.mn сайтад нийтэлсэнээр 70 мянга гаруй хэрэглэгчтэй болж, 312 мянга гаруй хандалт авсан. Хөдөлгөөнт дүрс, тоглоомын элементүүдээр агуулгыг нь баяжуулж хөдөөгийн сургуулиуд ашиглахад хялбар болгосон. Эдгээр цахим хэрэгслүүдийг хэрхэн уялдуулж ашиглах, цахим сургалтын орчныг хэрхэн сайжруулах талаарх сургалтад улсын хэмжээнд 1300 гаруй багш, сурган хүмүүжүүлэгчид хамрагдсан. НҮБ-ын зүгээс сургуулийн өмнөх болон бага боловсролын үндэсний хөтөлбөрийг жендэрийн мэдрэмжтэйгээр шинэчлэх, уур амьсгалын өөрчлөлт, цахим шилжилтийн үед учирч болзошгүй сорилтуудыг шийдвэрлэх зэрэгт чиглэсэн дэмжлэг үзүүлж байна.

Нотолгоонд суурилж бодлого, шийдвэр гаргахыг дэмжиж боловсролын салбарын онцгой байдлын бэлэн байдалд үнэлгээ хийхэд НҮБ-ын зүгээс дэмжлэг үзүүлж, жендэр, цахим хүчирхийлэл, зудын гамшгийн бэлэн байдлыг хангах зэрэг асуудлаар сэтгүүлчдэд зориулсан сургалт хийлээ. Түүнчлэн Цахим үндэстэн болох стратегийн зорилттой нийцсэн баримт мэдээлэлд тулгуурласан шийдвэр гаргалтыг хэвшүүлэх, цахим ертөнц дэх Монголын Хэвлэл

мэдээллийн боловсролын талаар баримтлах бодлогын төслийг боловсруулахад дэмжлэг үзүүлэв.

Насан туршийн боловсролын хүртээмжийг өргөжүүлэх нь анхаарах асуудал хэвээр байна. Бэлгийн боловсрол, хичээлээс гадуурх Шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик (ШИМТ)-ийн хөтөлбөр, Ус, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн хөтөлбөрүүд, сургуулиас гадуурх, завсардсан хүүхдүүдийн асуудлаар хяналт шинжилгээ хийх мэргэжилтнүүдэд зориулсан сургалт зэрэг ур чадвар дээшлүүлэх хөтөлбөрүүдэд нийтдээ 54 мянга гаруй хүн хамрагдсан.

Сургуулийн эрүүл мэндийн хяналтын тогтолцоо, эрүүл мэндийн үйлчилгээний үнэлгээг хэвшүүлж, Аюулгүй сургууль санаачилгыг ерөнхий боловсролын 33 сургуульд хэрэгжүүлснээр суралцагчдын тав тух аюулгүй байдал сайжирсан. Цаашлаад, НҮБ-аас 2023 оны Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайланг олон нийтэд танилцуулахад дэмжлэг үзүүлж, тэгш, хүртээмжтэй боловсролын технологи, Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хэрэглүүрийн хүртээмж, цахим бичиг үсгийн талаарх яриа хэлэлцүүлгийг өрнүүлж ажилласан.



'Girls Code' хөтөлбөр нь ирээдүйн программ хангамжийн эмэгтэй инженерүүдийг бэлтгэх суурь болно. ©НҮБХС

Нийгмийн болон хүүхэд хамгааллын бодлого, тогтолцоо (нийгмийн даатгал, нийгмийн халамж, хөдөлмөрийн зах зээлийн хөтөлбөрүүд) нь хүн бүрийг нийгмийн хамгааллын үйлчилгээнд эрх тэгш хамруулж, хямрал цочролд тэсвэртэй, тогтвортой хөгжиж хүн амын эмзэг хэсгийг найдвартай хамгаалах чадавхтай болно.

Хөдөөгийн иргэдийн эрүүл мэндийг дээшлүүлэхэд:



1.33

сая хүүхэд хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хөтөлбөрийн үр шимийг хүртэж байна.

Зудын гамшгийн үед



6500

өрхөд тус бүр

660,000

төгрөгийн хүмүүнлэгийн тусламж олгосон

Нэгдсэн Үндэстний Байгууллага 2024 онд Монгол Улсын нийгмийн болоод хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр бодитой алхам хийж, эмзэг бүлгийн хүн амыг илүү сайн хамгаалахын тулд тэгш байдал, хамрах хүрээ, тогтвортой байдалд анхаарал хандуулж ажиллалаа. НҮБ-ын манлайлал нөлөөллийн үр дүнд хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хөтөлбөрийг өргөжүүлж өнөөгийн байдлаар 1.33 сая хүүхдэд хүрч байгаа нь бодитой ахиц юм. Тус хөтөлбөрийн төсөв 2025 онд 1,580.2 сая төгрөг болж нэмэгдсэн нь тусламж нэн шаардлагатай байгаа өрхүүдэд багагүй дэмжлэг болно.

НҮБ-ын техникийн туслалцаатайгаар боловсруулсан Нийгмийн даатгалын багц хуулийг хэрэгжүүлснээр нийгмийн даатгалын шинэчлэлийг ахиулна. Хууль батлагдсанаар бэлчээрийн мал аж ахуй эрхлэгч малчид болон албан бус хөдөлмөр эрхлэгчдийг хамруулсан тэтгэврийн олон шатлалт тогтолцоог нэвтрүүлж, тэтгэмжийг инфляцийн түвшинтэй уялдуулан индексжүүлж, тэтгэврийн насыг уялдуулж, хугацаа хэтэрсэн шимтгэлийг хасч, илүү шударга, тогтвортой хамрах хүрээг бүрдүүлнэ.

Зудын гамшгийн үед НҮБ-ын яаралтай тусламжийн хөтөлбөрийн хүрээнд бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг эмзэг бүлгийн нийт 6500 өрхөд яаралтай бэлэн мөнгөний тусламж үзүүлэх зохицуулалт хийж, амьжиргааг нь тогтворжуулах зорилгоор нэг өрхөд 660,000 төгрөгийн тусламж үзүүлсэн.

Эрсдэлт бүлгийг эрт илрүүлэх механизмыг нэвтрүүлэх, үйлчилгээ үзүүлэгчдийг чадавхжуулах, хамгаалах байрны дэд бүтцийг сайжруулах замаар хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлж байна. 2024 онд нийт 9900 хохирогч хүүхдийг илрүүлж нийгмийн үйлчилгээнд хамруулсан бөгөөд НҮБ-ын дэмжлэгтэйгээр Архангай аймагт хэрэгжиж буй туршилтын төслийн хүрээнд эрсдэлт бүлгийн 284 хүүхдийг олж илрүүлсэн нь нутгийн иргэдэд тулгуурласан арга хэмжээ ихээхэн чухал болохыг харуулж байна. Түүнчлэн НҮБ-ын зүгээс жендэрийн тэгш бус байдалд иж бүрэн дүн шинжилгээ хийж, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн (CRPD) талаарх сургалтыг зохион байгуулах замаар эрх зүйн шинэчлэлд тодорхой хувь нэмэр оруулж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн оролцоог дэмжих засгийн газрын чадавхыг бэхжүүлсэн.



НҮБ-ын Суурин зохицуулагчийн удирдлага дор Монгол Улс дахь НҮБ-ын Хүмүүнлэгийн баг зудад нэрвэгдсэн малчдад амин чухал дэмжлэг үзүүлэхэд хүчээ нэгтгэв. ©ОУШХБ / Д. Давааням

Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, жендэрийн мэдрэмжтэй, хүн бүрт хүртээмжтэй, хямд төсөр, чанартай ундны ус, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн үйлчилгээг хүн бүрт хүргэх хүчин чадалтай болно.

Ус, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн орчныг сайжруулахад оруулсан дэмжлэгийн үр дүнд:



9

сургууль



43

нэгж байгууллага



200,000

хүн цэвэр орчинд ажиллаж, суралцах боломжтой боллоо.

НҮБ 2024 оны туршид Монгол Улсад бүх нийтийн хэрэгцээг хангах, уур амьсгалын өөрчлөлтийг сөрөн тэсвэрлэх чадвартай, жендэрийн мэдрэмжтэй Ус, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн үйлчилгээг хөгжүүлэхэд анхаарал хандуулж, бодлого боловсруулах, дэд бүтцийг сайжруулах, ур чадварын сургалт зохион байгуулах зэргээр дэмжлэг үзүүлээ. Ус, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн үйлчилгээний талаарх үндэсний бодлого боловсруулахад НҮБ-ын системийн байгууллагууд техникийн туслалцаа үзүүлсэн нь Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр нийгмийн хариуцлагынхаа хүрээнд 100 тэрбум төгрөгийн (29.5 сая ам. доллар) хөрөнгө оруулалт хийхэд нөлөөлж чадсан. Энэ санхүүжилтийн дэмжлэгтэйгээр хөдөө орон нутгийн 241 сургууль, дотуур байр, цэцэрлэгийг ариун цэврийн өрөө, гар угаалгын өрөөтэй болгох ажлыг төлөвлөж, 2024 оны санхүүгийн жилд нийт 43.4 тэрбум (12.8 сая ам.) төгрөгийн санхүүжилтийг хийсэн байна.

цэвэрлэх систем зэрэг нэн шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлснээр онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах чадавхид дэмжлэг үзүүлсэн. Дэлхийн ариун цэврийн байгууламжийн үйлчилгээ, ундны усны хангамжид хийх дүн шинжилгээ, үнэлгээ (GLAAS) судалгаанд НҮБ-ын дэмжлэгтэйгээр Монгол Улс оролцсон нь Ус, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн үйлчилгээний талаар баримтлах бодлогыг таниулах чухал мэдээллийн сантай болсон. Салбарын хүний нөөцийг хөгжүүлэх зорилгоор эрүүл ахуйн байцаагч нарт зориулсан сургалтыг зохион байгуулсан нь хяналтын тогтолцоог шинэчлэхэд чухал түлхэц болсон. 200 мянга гаруй хүнийг хамарсан 'Энхийн төлөөх ус, ариун цэврийн байгууламж' кампанит ажлын хүрээнд олон нийтийн ойлголт мэдлэгийг дээшлүүлж, Ус, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн үйлчилгээний бүх нийтийн хүртээмжийг сайжруулах үйлсэд олон нийтийн оролцоо онцгой чухал болохыг нотолсон.

Ус, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн баталгаат үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор НҮБ-аас эрүүл мэндийн байгууллагуудад аюулгүй байдлын төлөвлөгөө гаргах, эрүүл мэндийн байгууллагуудын Ус, ариун цэврийн байгууламжийг сайжруулах зэрэг төслүүдэд дэмжлэг үзүүлсний ашиг тусыг гурван аймгийн 200 мянга гаруй хүн, эрүүл мэндийн 43 нэгж байгууллага, 9 сургууль хүртлээ. Онцгой байдлын ерөнхий газарт усны шахуурга насос, зөөврийн бие засах газар,



Баянхонгор аймгийн сургуулийн шинээр барьсан ариун цэврийн байгууламж ©НҮБХС/2024

Хүн амын эмзэг хэсэгт онцгой анхаарал хандуулахын зэрэгцээ хүн бүр шим тэжээллэг, эрүүл хоол хүнсийг зохистой түвшинд хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх, хамгаалах, дэмжих чадавх бэхжсэн байна.



16,000+

гаруй хүүхэд, жирэмсэн, хөхүүл эхчүүдэд нэн шаардлагатай хоол, шим тэжээлийн тусламж хүртсэн



2

Дотор мах, дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр байгуулагдсан.

Тус улсад тохиолдож байгаа элсэн чихрийн хэт их хэрэглээ болон хоолны дэглэмээс үүдэлтэй өвчлөлийг бууруулах зорилгоор Монгол Улс 2027 оноос бүх төрлийн чихэрлэг ус ундаанд онцгой албан татварыг ногдуулахаар шийдвэрлэсэн нь бодлогын чухал алхам болсон. Түүнчлэн НҮБ-ын дэмжлэгтэйгээр сургуулийн хоолны өртөг зардлын дүн шинжилгээ хийсний үр дүнд сургуулийн хоолны төсөв 62 хувиар нэмэгдэж сургуулийн сурагчдын хоол тэжээлийн байдал сайжирч байна.

Нотолгоонд суурилсан үйл ажиллагааг бэхжүүлэх зорилгоор хоол тэжээлийн дутагдал, таргалалт, бичил тэжээлийн дутагдлын талаарх чухал ойлголтуудыг тусгасан Хоол тэжээлийн үндэсний дөрөв дэх удаагийн судалгааг зохион байгуулахад Эрүүл мэндийн яаманд дэмжлэг үзүүлэв. 'Fix My Food', 'Эрүүл хүн 1000 хүсэлтэй' зэрэг хүүхэд залуучууд өргөнөөр оролцсон санаачилгууд нь залуучуудад эрүүл хооллолтыг сурталчлах боломж олгосон.

Зудын гамшгийн үед 16 мянга гаруй хүүхэд, жирэмсэн, хөхүүл эхчүүдэд нэн шаардлагатай хоол тэжээлийн тусламж үзүүлсэн. Урт хугацааны арга хэмжээнүүд нь Нярай болон бага насны хүүхдийн хооллолтын талаар зөвлөгөө өгөх, цочмог хоол тэжээлийн дутагдлын менежментийг өргөжүүлж, улсын хэмжээнд эрүүл мэндийн 650 гаруй ажилтныг сургалтад хамруулсан. "Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих Арван алхам" хөтөлбөрт шинээр төрсөн нийт нярайн 70

гаруй хувь нь хамрагдаж, нэмэгдэл бичил тэжээл олгох хөтөлбөрт 41 мянга гаруй эхчүүд хамрагдсан байна.

Хоол тэжээлийн дэглэмийн төрөлжүүлэлтийг дэмжих зорилгоор НҮБ-ын ХХААБ-аас гаргасан Хоол тэжээлийн дэглэмийг төрөлжүүлэх гарын авлагыг орчуулах, дотор мах, дайвар бүтээгдэхүүний шим тэжээлийн судалгаа явуулах, 100 гаруй нэр төрлийн шинэ жор танилцуулсан үндэсний хоол хийх уралдааныг зохион байгуулах зэрэгт НҮБ-аас дэмжлэг үзүүллээ.

Хоол тэжээлийн дэглэмийг төрөлжүүлэх, сургуулийн сурагчдын хоолны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хүүхдийн хоол тэжээлийг сайжруулах зэрэгт чиглэсэн нотолгоонд суурилсан бодлогыг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх замаар Монгол Улсын хүнсний тогтолцоог бэхжүүлэхэд НҮБ чухал үүрэг гүйцэтгэж байна. Үндэсний хоол тэжээлийн хэрэглээг дэмжих замаар монголчуудын хоол тэжээлийн дэглэмийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд шим тэжээлээр баялаг дотор мах, дайвар бүтээгдэхүүнийг дээд зэргээр ашиглах, хүнсний хаягдлыг багасгах, дотор мах, дайвар бүтээгдэхүүнээр үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүний судалгаа, хөгжүүлэлтийн ажлыг дэмжив. Энэхүү техникийн болоод стратегийн тусламжийн хүрээнд дотор мах, дайвар бүтээгдэхүүн боловсруулах хоёр үйлдвэр байгуулж, хүнсний шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлсэн.



Сургуулийн сурагчдын хоолны хөтөлбөрт оруулсан хөрөнгө оруулалт нь ирээдүйд хамгийн сайн үр дүнг авчрах хөрөнгө оруулалт юм. ©НҮБХХААБ

Цахим технологи эрүүл мэндийн үйлчилгээг Монгол гэр бүлд ойртуулж байна

Дөрвөн хүүхдийн ээж, малчин Ганбаатарын Мөнхсүрэн Эрдэнэ сумын багт амьдардаг. Төвөөс хол амьдардаг малчдын хувьд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахад олон бэрхшээл тулгардаг. Ялангуяа өвлийн хүйтэн, их цастай үед зам тээврийн нөхцөл хүндэрч, бүр ч хэцүү.

"Өвөл эмнэлэгт үзүүлэхийн тулд мотоциклоор явах амаргүй байдаг" хэмээн тэрээр ярьж байна. Монгол Улсын бүх сум, баг руу хатуу хучилттай зам тавигдаагүй, дээрээс нь мэргэжлийн эмч, сувилагчдыг орон нутагт татан ажиллуулахад хүндрэлтэй хэвээр байна. Энэ нь хөдөө орон нутагт амьдарч буй олон малчин өрх, түүний дотор Мөнхсүрэнгийнх шиг айл өрхүүдийг төв суурин газар зориход хүргэдэг.

"Эрүүл мэнд бол хамгийн үнэтэй зүйл. Хүн эрүүл байж л аз жаргалтай, сэтгэл хангалуун амьдарна" гэж тэр ярьж байна.

Тиймээс төрөөс хэрэгжүүлж буй цахим шийдлүүд малчин өрхүүдэд нийгмийн үйлчилгээг ойртуулж байна. Монгол Улсын Цахим үндэстэн болох их зорилтын хүрээнд эрүүл мэндийн үйлчилгээг хөдөө орон нутагт илүү хүртээмжтэй болгох чиглэлд анхаарч ажиллаж байна.

2020 онд нэвтэрсэн eMongolia аппликейшн нь хөдөөгийн иргэдэд төрийн үйлчилгээг хурдан шуурхай авах нөхцлийг бүрдүүлсэн. Энэхүү платформоор дамжуулан иргэд эмнэлгийн цаг авах, эмчийн зөвлөгөө авах, эрүүл мэндийн бүртгэлтэй танилцах, шаардлагатай мэдээллийг шуурхай хүлээн авах боломжтой болсон юм.

Хамгийн сүүлд эх, хүүхдийн яагаан дэвтрийг цахим болгосон нь эмч, эмнэлэгийн ажилтнууд болон гэр бүлүүдийн талархлыг хүлээж байна.

"Энэ бол ёстой чухал шийдвэр болсон. Яагаан дэвтэр цахим болсноор цаг хугацаа хэмнэж, айл өрхүүдийн амьдралыг бас хялбарчилж байна" хэмээн Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн дарга М.Түвшинтамир онцолж байна.

Тухайлбал, Г.Мөнхсүрэн одоо бага охиныхоо дархлаажуулалтын талаар сануулгыг гар утсандаа цаг тухайд нь авч байна. "Вакцин хийлгэхийн тулд хаашаа, хэдийд явах вэ гэж санаа зовох шаардлагагүй болсон. Бүх мэдээлэл бидэнд шууд ирдэг" гэж тэрээр сэтгэл хангалуун хэлж байна.

Түүний хувьд эдгээр цахим хэрэгслүүд нь амьдралд зөвхөн тав тух авчраад зогсохгүй хүүхэд бүр **эрүүл саруул, аюулгүй орчинд өсөж торних нөхцөлийг бүрдүүлж байна гэв**. "Хүн эрүүл л байвал ямар ч мөрөөдлөө биелүүлж чадна" гэж тэрээр онцлов.



Илүү эв нэгдэлтэй нийгэмд жендэрийн эрх тэгш байдал, хүний эрх, нэн ялангуяа шилжин суурьшигчдын эрхийг хүндэтгэн хамгаалах, хүртээмжтэй, оролцоог хангасан, олон салбарыг хамарсан, жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг дорвитой хариу арга хэмжээ авах механизмыг бий болгох институт болоод чадавхыг бэхжүүлнэ.

ЖСХ-тэй тэмцэх чиглэлээр: Хүчирхийллийн хохирогчдод туслах Нэг цэгийн үйлчилгээний төвөөр 2024 онд нийт



4834

хүн үйлчлүүлсний



3073

нь хүүхэд байв.

2024 онд НҮБ нь Монгол Улсын Жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ)-ийн эсрэг авч буй арга хэмжээг ахиулах, энэ талаар баримталж буй төрийн бодлогыг уялдуулах, системийн цоорхойг арилгахад чиглэсэн бодит үр дүн гаргахад чухал үүрэг гүйцэтгэлээ. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний дунд хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлж, Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйлчилгээ нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ЛГБТ+ бүлгүүдэд хэр хүртээмжтэй байгааг судалж үнэлгээ хийсэн нь гол амжилт байлаа.

НҮБ нь шинээр гарч ирж буй сорилтуудыг анхааралдаа авч, Технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх асуудлаар өндөр түвшний яриа хэлэлцүүлэг зохион байгуулж, үүний үр дүнд Монгол Улсын Үйл ажиллагааны уриалгыг баталж, Технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх арга хэмжээг тодорхойлсон. Эрүүл мэндийн салбарын бэлэн байдлыг бэхжүүлэхийн тулд анагаахын их сургуулийн суурь сургалтын хөтөлбөрүүдэд ЖСХ-ийн талаарх ойлголтыг тусгаж өгсөн.

Нийгмийн ажилтнууд, цагдаа, багш нар, сэтгүүлчид, Нэг цэгийн үйлчилгээний төв, хамгаалах байрны ажилтнуудад зориулсан чадавх бэхжүүлэх ажлыг удирдан зохион байгуулахад НҮБ дэмжлэг үзүүллээ. НҮБ нь Нэг цэгийн үйлчилгээний төвүүдийг засч тохижуулах, шаардлагатай тоног төхөөрөмж,

хэрэгслээр хангахад байнгын дэмжлэг үзүүлж байна. Эдгээр цэгээр 2024 онд нийт 4834 хүн үйлчлүүлсний 3073 нь хүүхэд байв.

НҮБ нь зудаа нэрвэгдсэн найман аймгийн эмэгтэйчүүд, охидод зориулсан аюулгүй газрыг байгуулж, тэргүүн шугамд ажиллах 229 ажилтанд сургалт явуулж, зудаа нэрвэгдсэн эмэгтэйчүүд, охидод зориулан бэлтгэсэн тусламжийн 8724 багц хүргүүлж ажилласан.



Орон нутгийн Онцгой байдлын албан хаагч зудын гамшигт нэрвэгдсэн эмэгтэйчүүд, охидод хүмүүнлэгийн тусламж болгон тусгайлсан багцийг хүргэж байна ©НҮБСЗГ



Стратегийн тэргүүлэх чиглэл 2: Ногоон, хүртээмжтэй, тогтвортой өсөлт



Үр дүнгийн зорилт 2:

2027 он гэхэд Монгол Улсын эдийн засаг илүү төрөлжсөн, эрс шинэлэг, бүтээмжтэй, хүртээмжтэй, 'ногоон' болж, бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангаж; ялангуяа эмэгтэйчүүд, залуучуудын зохистой амьжиргааг тэтгэх, 21-р зууны эрэлт хэрэгцээтэй ур чадварыг хөгжүүлэх, нүүрсхүчлийн хий бага ялгаруулах хөгжлийг дэмжинэ.

Монгол Улс эдийн засгийн өсөлтөөрөө 2024 онд дундаас дээш орлоготой улс орны түвшинд хүрсэн нь чухал үзүүлэлт юм. 2023 онд Монгол Улсын ДНБ 70.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оныхоос 30.8 хувиар өссөн байна. Гэвч дэлхий нийтэд нүүрсний эрэлт буурч, уул уурхайн олборлолтын хэмжээ буурсан нь үйлдвэрлэлийн салбарт нөлөөлснөөр 2024 онд эдийн засгийн тэлэлт 4.9 хувь болж саарчээ.

Гэвч эдгээр ололт амжилт хэр тогтвортой байх нь эргэлзээтэй хэвээр байна. Уул уурхайн салбараас бусад салбарын өсөлтийг дэмжихийн зэрэгцээ, ялангуяа эмзэг бүлгийн хүн амд хүртээмжтэй, тогтвортой хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хүчин чармайлтаа НҮБ үргэлжлүүлж байна. Зах зээлийн шаардлагад нийцсэн сургалтын тогтолцоог бэхжүүлж ажлын байр нэмэгдүүлэхийг дэмжсэн хуулийн заалтуудыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг сайжруулж байна. Залуучуудын оролцоо, цахим технологи, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг идэвхжүүлж, ажлын байрны танилцуулга,

нийцлийг сайжруулах, шилжин суурьшигчид болон эмзэг бүлгийн хүн амд илүү ашиг тустай байх зорилтот стратеги боловсруулахад дэмжлэг үзүүлж байна.

Ногоон шилжилтийн төлөөх хүчин чармайлтуудын нэг хэсэг болгон НҮБ нь бодлогын зөвлөгөө, загварчлалын шийдэл, уур амьсгалын санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлэх, ил тод байдлыг сайжруулах, борлуулалтыг хурдасгах, бүтээгдэхүүний алдагдлыг бууруулах, эцсийн дүндээ салбарын үр ашиг, ашиг орлогыг нэмэгдүүлэх зорилгоор цахим худалдааны платформыг хөгжүүлэхийг дэмжиж ажиллалаа.

Монгол гэрийн дулаалга, халаалт, зуухыг сайжруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний олон төрлийн санхүүжилтийн стратеги хэрэгжүүлснээр айл өрх, үйлдвэрлэгчдийн хоёуланд нь ашиг тустай байх төдийгүй жижиг, дунд үйлдвэрүүдийг чадавхжуулах, тэдний нийгэмд үзүүлэх нөлөөг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулж байна.



НҮБ нь Монгол Улсын тогтвортой ноолуурын платформд дэмжлэг үзүүлж байна ©НҮБХХ

Эмэгтэйчүүд, залуучуудын ур чадвар эзэмших, дахин мэргэших боломжийг өргөжүүлж бизнес эрхлэх сургалтыг зохион байгуулан тэдний зохистой хөдөлмөр эрхлэх, ажилд ороход шаардагдах бүтээлч чадварыг дээшлүүлэх, түүнчлэн дотоод, гадаадын шилжих хөдөлгөөнийг илүү үр дүнтэй удирдах зэргээр эмэгтэйчүүд, залуучууд, орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүдийн ажиллах хүчний оролцоог нэмэгдүүлэх институцийн чадавхыг бэхжүүлнэ.



1100

гаруй залуус
цахим ур чадвар
эзэмшив.

Хууль эрх зүйн орчин бүрдүүлэх өмнөх амжилтдаа тулгуурлан, НҮБ нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлж байна. Энэ хүрээнд Ажил, хөдөлмөр эрхлэлтийн салбарт үр дүнд суурилсан төсөвлөлтийг нэвтрүүлж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүждэг хөдөлмөр эрхлэлтийн үндэсний хөтөлбөрүүдийг шинэчлэн боловсруулж, эмэгтэйчүүд, залуучуудын ур чадвар, амьжиргааг дээшлүүлэх чиглэлээр дэмжин ажиллалаа.

Түүнчлэн төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний хүрээнд үндэсний болон орон нутгийн түвшинд ажлын байрны танилцуулга хийх арга хэрэгслийг боловсруулж хэрэгжүүлэх, улмаар ажил хайгчдад ур чадвар, сонирхол, хувийн сонголтоо зах зээлд байгаа ажлын боломжуудтай нийцүүлэхэд нь туслах чиглэлээр НҮБ дэмжлэг үзүүлээ.

НҮБ, Монгол Улсын Засгийн газар, Юнител хоорондын сайн түншлэлд тулгуурлан Залуучуудын хөгжлийн төвүүдийг түшиглэн UNITEL HUB хөтөлбөр хэрэгжүүлж 1100 гаруй өсвөр насныхан, залуучуудад код бичих, робот техник, электроникийн суурь ур чадвар, ирээдүйд шаардагдах чухал ур чадвар эзэмшүүлэх төслүүдийг хэрэгжүүллээ.

НҮБ нь Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим (МҮХАҮТ)-тай хамтран бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг чадавхжуулах, зах зээлд нэвтрэх, харилцаа холбоо тогтоох, мэдлэг мэдээлэл хуваалцах чиглэлээр дэмжлэг үзүүлсэн. Түүнчлэн, НҮБ нь зорилтот бодлого боловсруулах, институцийн чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрүүд хэрэгжүүлэх замаар залуучуудын дунд ногоон бизнес эрхлэлтийг дэмжиж ажиллалаа. Хот, хөдөөгийн сэргэлт, газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн Үндэсний хороог байгуулахад дэмжлэг үзүүлж, дотоодын шилжин суурьшигчдын хамгаалалтыг сайжруулахад анхаарч ажилласан.

Монгол дахь “Эрчим хүчний шилжилтийн манлайлагч” хөтөлбөр нь тэгш, хүртээмжтэй эрчим хүчний шилжилтийн үед залуучуудыг чадавхжуулах шинэлэг туршилтын төсөл юм. Тус төслийн хүрээнд залуучууд их, дээд сургуулийн мэргэжлийн багш нартай ажиллан заавар зөвлөгөө авах, сургуулийн орчинд ашиглаж болох сэргээгдэх эрчим хүчний шийдлүүдтэй танилцаж практик мэдлэгтэй болох боломжийг бүрдүүлнэ. Эрчим хүчний асуудлыг илүү гүнзгий ойлгож судалснаар залуучууд онолын мэдлэгээ практик, бодит хэрэглээ болгон хувиргах боломж бүрдэнэ.



Өмнөговь аймгийн Даланзадгад дахь Юнителийн төвд робот угсарч буй залуус, 2024. ©UNFPA

Эдийн засгийг төрөлжүүлж, нөөцийг үр ашигтай зарцуулах арга хандлагад шилжих, нүүрсхүчлийн хий бага ялгаруулах хөгжил, дижитал хувьсалыг дэмжих, улмаар өрсөлдөх чадвартай, технологийн хувьд эрс шинэлэг, бүтээмжтэй эдийн засгийг хөгжүүлэх, жижиг аж ахуйн нэгжүүд илүү ногоон үйл ажиллагаа эрхлэх, олон улсын нэмүү өртгийн сүлжээнд холбогдох, албан ёсны эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, нөөцийг үр ашигтай, тогтвортой ашиглах зэрэг нөхцөлийг хангасан бодлого, стратеги, институцууд бий болсон байна.



2,300+

гаруй өрх эрчим хүчний хэмнэлттэй гэрийн дулаалга, халаалт, зуухны багцтай болсноор нүүрс түлэхээс татгалзав

Монгол Улс нь НҮБ-ын дэмжлэгтэйгээр уур амьсгалын өөрчлөлтийг сөрөн тэсвэрлэх чадавх бүрдүүлэх, нүүрстөрөгч бага ялгаруулах хөгжлийн зорилгын хэрэгжилтийг хурдасгаж байна. Уур амьсгалын Үндэсний хороо нь Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний төлөвлөгөөг баталж, түүний санхүүжилтийн стратеги, хяналт шинжилгээ, үнэлгээний хүрээг тодорхойлсон. Бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчид Харвардын Кеннедигийн сургууль, Тафтсын их сургуулиас зохион байгуулсан тусгай сургалт, уур амьсгалын өөрчлөлтийн зураглал боловсруулах сургалт семинарт хамрагдсанаар уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавх нь сайжирсан. Тэгш, хүртээмжтэй эрчим хүчний шилжилтийн асуудлаарх Хүний хөгжлийн үндэсний баримт бичигт Монгол Улсад эрчим хүчний шинэчлэл хийх, Хүлэмжийн хийн ялгаруулалтыг тэглэх (NetZero) стратегийг боловсруулах шаардлага байгааг зөвлөмж болгосон. Мөн НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн туршилтын төслийн хүрээнд эмзэг бүлгийн 69 өрх, ялангуяа өрх толгойлсон эмэгтэйчүүдэд ашиг тустай, нарны сэргээгдэх эрчим хүчинд түшиглэсэн халаалтын шийдлийг нэвтрүүлсэн.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас залуучуудын тогтвортой орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор “Хүүхэд, залуучууд, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх үйл ажиллагааны тухай” олон улсын тунхаглалд нэгдэж байгааг зарласан. Санхүүгийн 9 байгууллагын нэг сая орчим ам.долларын буцалтгүй тусламж, ногоон зээлийн санхүүжилтээр дэмжигдсэн Гэрийн халаалт, дулаалга, зуухны багц (CHIP)

хөтөлбөрт 2300 гаруй өрх хамрагдаж, нүүрс хэрэглэхээ зогсоосон. Агаарын бохирдлын асуудлаар 6384 хүүхэд, өсвөр насныхан, 153 багш, эцэг эхчүүдэд, нарны эрчим хүчний асуудлаар 35 сургууль, эрүүл мэндийн байгууллагын удирдлагуудад зориулсан сургалтыг тус тус зохион байгууллаа.

НҮБ нь Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоотой хамтран чадавх бэхжүүлэх чухал санаачилга болох “Бизнесээ албан ёсоор эрхэл” сургалтын хөтөлбөрийг боловсруулж гаргасан. Засгийн газартай хамтран бизнесийг албан ёсны хэлбэрт шилжүүлэх, албан бус болон стандарт бус хэлбэрийн ажил, хөдөлмөр эрхэлж буй хүмүүст зориулсан хөдөлмөрийн гэрээний загварын цахим шийдлүүдийг боловсруулахад НҮБ дэмжлэг үзүүлэв. Түүнчлэн МҮХАҮТ-аас НҮБ-тай хамтран бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардагдах зардлын үнэлгээ хийх зорилгоор “Хүнд суртлын саад бэрхшээл” судалгааг явуулж, бодлогоо сайжруулахад чухал ач холбогдолтой мэдээллийн сантай болсон.

Нүүрсхүчлийн хий бага ялгаруулах хөгжлийн эрх зүйн орчныг бэхжүүлэхийн тулд хүнсний аюулгүй байдал, малын эрүүл мэнд, газар тариалантай холбоотой гол хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах чиглэлээр НҮБ-ын зүгээс Монгол Улсын Их хуралд дэмжлэг үзүүллээ. Тухайлбал, 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдөр Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийг шинээр, мөн Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг тус тус баталсан.



Улаанбаатар хотын гэр хорооллын айлуудад нарны эрчим хүч түшиглэсэн халаалтын шийдлийг нэвтрүүлэх НҮБ-ын туршилтын төсөл. ©НҮБХХ

Ил тод, урьдчилан тооцоолох боломжтой хөрөнгө оруулалтын орчныг бүрдүүлэх, үр ашигтай, нүүрсхүчлийн хий бага ялгаруулах хөгжилд чиглэсэн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих эрс шинэлэг санхүүжилтийн тогтолцоог бий болгох Засгийн газрын чадавх бэхжиж, бизнесийн хариуцлагатай хэрэглээ, үйлдвэрлэлийг дэмжих, хүний эрхийг дээдлэх, нийгэм, байгаль орчин, өмч хөрөнгөд ээлтэй бодлогууд хэрэгжинэ.

Газрын тогтвортой менежмент



226,000
гаруй га атаршсан
талбайг сэргээв



Газар
тариалангийн
талбайг
200,000
га-гаар
нэмэгдүүлэв.

2024 онд Монгол Улсад тогтвортой санхүүжилтийг хөгжүүлэхэд ихээхэн ахиц гарсан. Үр дүнд суурилсан төсвийг үндэсний болон орон нутгийн түвшинд үе шаттайгаар нэвтрүүлж, нэгдсэн төсөв боловсруулах аргачилсан удирдамжийг боловсруулж баталсан. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Боловсролын яам 2023 оны төсвийн гүйцэтгэлд суурилсан анхны тайлангаа гаргалаа. Түүнчлэн, Сангийн яам уур амьсгалын санхүүжилтэд онцгойлон анхаарч, Үндэсний санхүүжилтийн нэгдсэн тогтолцооны хэрэгжилтийн төлөвлөгөөг албан ёсоор батлав. Энэ ажлын хүрээнд Засгийн газрын ТХЗ-тай нийцсэн бондын хүрээг нэвтрүүлж, мал аж ахуйн салбарт ногоон зээл гаргах удирдамжийг боловсруулж үндэсний хэмжээнд батлуулахаар өргөн бариад байна.

Нүүрстөрөгчийн зах зээлийн тухай зургадугаар зүйлд туссан зөвлөмжүүдийг багтаасан уур амьсгалын санхүүжилтийн бодлогын талаар нөлөөлөл сурталчилгаа хийхэд НҮБ дэмжлэг үзүүллээ. “Уур амьсгалын хөрөнгө оруулалт” төслийн хүрээнд ногоон хөрөнгө оруулалтын боломжит сувгууд, хувийн хөрөнгө оруулалтыг дайчлах стратегийг боловсруулсан. Монголбанкны үйл ажиллагааг ногоон болгох хөтөлбөрийн хүрээнд уур амьсгал санхүүжилтийн эрсдэлийн үнэлгээг хийж, мөнгөний бодлого болон банкны үйл ажиллагааг илүү ногоон болгох алсын харааг тодорхойлсон.

Сэлэнгэ аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, Сэлэнгэ аймгийн 17 сум, Хэнтий аймгийн Биндэр сумын Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулах, газрын тогтвортой менежментийг нутагшуулахад НҮБ-ын зүгээс дэмжлэг үзүүлсэн. Эдгээр хүчин чармайлт нь газар ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх, экологийн тэнцвэрийг хадгалахад чиглэсэн.

НҮБ-ын дэмжлэгтэйгээр үндэсний хэмжээнд хийсэн газар тариалангийн талбайн үнэлгээний үр дүнд тариалангийн нийт талбайн иж бүрэн зураглал гаргаж, газар тариалан эрхлэхэд тохиромжтой атаршсан 226 мянган га тариалангийн талбайг олж тогтоосон. “Хүнсний хангамж, аюулгүй байдал” хөтөлбөрийн хүрээнд улсын нийт тариалангийн талбайг 200 мянган га-аар нэмэгдүүлэх үндэсний зорилтыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулахаар судалгааны үр дүнг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлээд байна.

Хэнтий аймагт НҮБ-ын дэмжлэгтэйгээр чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж мах, махан бүтээгдэхүүний өртгийн сүлжээг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлсний үр дүнд төслийн зорилтот сумдын мал сүргийн тоо толгой 6 хувиар буурч, малчдын орлого нэмэгдэж, бэлчээрийн дарамт багасч байна.

Сэлэнгэ аймгийн Түнхэл суманд мөнгөн ус ашиглахгүйгээр алт олборлох үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор нийгэмд ээлтэй бизнес загварыг хэрэгжүүлж, олборлогчдын санхүүгийн тогтвортой байдлыг дэмжих зорилгоор Хадгаламж, зээлийн хоршоо байгуулжээ. Үнэт металл, үнэт эдлэлийн чуулга уулзалтыг зохион байгуулж санхүүгийн гол байгууллагуудыг оролцуулсан бөгөөд тус чуулганд нийт 108 хүн оролцсон. Мөнгөн ус ашиглахгүйгээр алт олборлох аргыг нэвтрүүлснээр Мандал, Түнхэл сумдыг 0.89 тонн мөнгөн усны бохирдлоос сэргийлж чадсан. Гар аргаар алт олборлогчид, алтны бичил уурхайчдын заавал дагаж мөрдөх дүрэм, журмын талаарх сургалт, туршлага солилцох уулзалтад 236 олборлогчид (тэдний 80 нь эмэгтэй) хамрагдсан. Сэлэнгэ, Ховд, Говь Алтай аймагт болсон Гар аргаар алт олборлогчид, алтны бичил уурхайчдын уулзалтуудад 146 олборлогч (тэдний 59 нь эмэгтэй) хамрагдсан бол Мандал суманд алтны худалдаа эрхлэгчдэд зориулсан цахим сургалт, бодлого боловсруулах арга хэмжээ зохион байгуулсан нь холбогдох зохицуулалтын хүрээг сайжруулахад хувь нэмэр оруулсан. Жендэрийн тэгш байдлыг хангах үүднээс зөвхөн эмэгтэйчүүдэд зориулсан технологийн сургалт зохион байгуулж, жендэрийн асуудлыг хөндсөн мэдээлэл тарааж, жендэрийн болоод хүний эрхийн үүднээс нийгмийн үйлчилгээний хүртээмж алт олборлогчдын дунд ямар түвшинд байгаа талаарх судалгаа хийсэн.

НҮБ нь Засгийн газрын ногоон зээл, орон нутгийн төсөв, банк, санхүүгийн байгууллагуудын хөнгөлөлттэй санхүүжилт зэрэг олон төрлийн санхүүжилтийн эх үүсвэрийг дайчилж Гэрийн халаалт, дулаалга, зуухны багц (CHIP) хөтөлбөрийн цар хүрээг өргөжүүлэхэд хувь нэмэр оруулж байна. Монгол Улсын Засгийн газар 2024 онд 1,170,300 ам.доллар буюу дөрвөн тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй ногоон зээлийг арилжааны гурван банкаар дамжуулан жилийн зургаан хувийн хүүтэй олгохоор шийдвэрлэсэн нь “CHIP” багц хөтөлбөрт хамрагдах шаардлага хангасан өрхүүдэд энэ дэмжлэгийг авах боломж нээгдсэн. Түүнчлэн Банк бус санхүүгийн зургаан байгууллага (ББСБ) арилжааны хүүнээс (18-19.2%) доогуур хүүтэй буюу орлогод нь нийцсэн ногоон зээлийг CHIP багцын эргэлтийн зохих сангуудаар дамжуулан зохих эх үүсвэрээс олгож байна. Өнөөгийн байдлаар банк, ББСБ-ын хөнгөлөлттэй ногоон зээлд 38 өрх хамрагдаж, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орон сууцны шийдэлд шилжихэд хувь нэмэр оруулж байна.

Уламжлалт сорилтыг технологийн тусламжтайгаар даван туулсан нь

Г.Билгүдэй бол малчдад уур амьсгалын өөрчлөлт болон байгалийн хатуу ширүүн нөхцөлд дасан зохицоход туслах "Оторчин" хэмээх цахим шийдлийг хөгжүүлсэн, нийгмийн хариуцлагатай залуу бизнес эрхлэгч юм.

Уг аппликейшний гол зорилго нь хиймэл дагуулын зураглалын үндсэн дээр малчдад хамгийн тохиромжтой бэлчээрийн байршлыг тодорхойлох боломжийг олгох явдал юм. Үүний зэрэгцээ уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгалийн гамшигт өртөх эрсдэлийг бууруулах, GPS-ээр малын байршлыг хянах, цаг агаарын мэдээлэл авах, яаралтай үед SOS дохио илгээх, төрийн үйлчилгээ болон тусламж авах зэрэг олон талын нэмэлт боломжуудыг мөн агуулдаг.

Билгүдэй өөрөө малчны гэр бүлээс гаралтай бөгөөд энэ санаа нь 2009 оны зудны үеэр тулгарсан бэрхшээлээс үүдэлтэй. Учир нь тэр жилийн зуднаар аав ээж нь хамаг малаа алдсан учраас хот руу нүүхээс аргагүйд хүрчээ. Ингэснээр уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн эмзэг, өртөмтгий байдаг малчдад тусалж, нүүдэлчин өв соёлыг хамгаалахыг хүссэн байна.

Түүний энэ санаачилга нь Дэлхийн Банкнаас зарласан олон улсын төслийн уралдаанд 1000 гаруй бүтээлээс шалгарч, эцсийн шатанд үлдсэн зургаан шилдэг төслийн нэгээр нэрлэгдсэн билээ.

Г.Билгүдэй "Оторчин"
аппликэйшнээ танилцуулж
байгаа нь. ©ОУШХБ

2027 он гэхэд Монголын нийт иргэд, экосистем нь нотолгоонд суурилсан, жендэрийн мэдрэмжтэй байгалийн нөөц, байгаль орчны тогтвортой менежмент, гамшгийн эрсдэлийг бууруулах чадавх сайжирснаар уур амьсгалын өөрчлөлтөд илүү тэсвэртэй болсон байна.

Эрсдэлийн удирдлага, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хүчин чармайлтад мал аж ахуй, бэлчээрийн менежмент, онцгой байдлын үеийн хариу арга хэмжээ, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг сааруулах үйл ажиллагааны төлөвлөлт зэрэг чиглэлээр институцийн чадавхыг бэхжүүлэх замаар ахиц дэвшил гарч байна. Нотолгоонд суурилсан стратеги нь уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэх эрсдэлийн загварчлалыг сайжруулах, эмзэг бүлгийн хүн амын бүлгүүдийн богино болон урт хугацаанд дасан зохицох төлөвлөгөө гаргах зэрэгт чухал ач холбогдолтой.

НҮБ-ын дэмжлэгтэйгээр Монгол Улс Биологийн олон янз байдлын үндэсний стратегиа 2020 оноос хойших Дэлхийн биологийн олон янз байдлын хүрээ баримт бичигтэй уялдуулсан. Биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээний Засгийн газар хоорондын шинжлэх ухаан-бодлогын платформ (IPBES)-оос тодорхойлсон экосистемийн 18 үйлчилгээнд байгалийн хөрөнгийн эдийн засгийн үнэлгээ хийж, үр дүнг нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгав. Энэ хуулиар байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг орон нутгийн (аймаг, сумдын) төсвөөс санхүүжүүлэхээр зохицуулсан.

Лабораторийн чадавхыг сайжруулж, үндэсний болон орон нутгийн түвшинд хүний нөөцийг хөгжүүлэхийн зэрэгцээ өвчлөлийн эрт сэрэмжлүүлэг, тандан судалгааны тогтолцоог бэхжүүлж байна. Түүнчлэн, хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээд илүү тогтвортой болж, зохистой арга

туршлагыг дэмжиж, хүнсний аюулгүй байдал сайжирч байна. Мөн ДЭМБ-аас гаргасан Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, байгаль орчинд ээлтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний газрын хүрээг Засгийн газар соёрхон баталж, гамшгийн бэлэн байдлыг хангах Эрсдэлийн цогц менежмент (CRM) болон Уур амьсгалын өөрчлөлтийг тэсвэрлэх чадамжийн үнэлгээний карт (CRS) зэрэг арга техникүүдтэй хослуулан ашиглаж байна. Уур амьсгалын эрсдэлийн индекс (CRI) болон нөлөөлд суурилсан урьдчилан таамаглах газрын зураглал зэрэг нь байгалийн эрс тэс үзэгдэлээс үүдэлтэй эдийн засгийн нөлөөллийг дүрслэн харуулах учир гамшгийн эсрэг хариу арга хэмжээний стратегийг боловсруулах үндэслэл болж байна.

Газар, усны менежментийг сайжруулах хүрээнд, тус улс нь Дорнод Монголын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалахын тулд тогтвортой мал аж ахуйг хөгжүүлэх стратеги, нутаг дэвсгэрийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг боловсруулсан. НҮБ-ын дэмжлэгтэйгээр, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй нөөцийн менежментийн арга барилыг өргөжүүлж, байгаль хамгаалах хүчин чармайлтаа илүү нэмэгдүүлж байна. Олон нийтэд түшиглэсэн эко аялал жуулчлалын загвар, малчин эмэгтэйчүүдэд чиглэсэн зорилтот хөтөлбөрүүд, Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоотой хамтран ажиллах зэргээр хөдөө аж ахуйн 160 гаруй жижиг, дунд үйлдвэр уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамжаа сайжруулж байна.



Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгийг сөрөн тэсвэрлэх чадамжийг бэхжүүлж, чадавхжуулах хөтөлбөрийн хүрээнд гамшигтай тэмцэх үед, ялангуяа, зудын хор уршгийг арилгах үед соёлын биет бус өвийг хамгаалахад гүйцэтгэх үүрэг, чадавхыг бэхжүүлэх тухай сургалт семинарт соёлын өв, гамшгийн эрсдэлийн менежментийн салбарыг төлөөлсөн 70 гаруй хүн оролцов.

Биологийн олон янз байдлыг хамгаалахад чиглэсэн газар ашиглалтын төлөвлөлт, тогтвортой хүнсний үйлдвэрлэл, ногоон бизнест хувийн хэвшлийг татан оролцуулах зэрэг олон хүчин чармайлтуудыг өөр хооронд нь уялдуулан нэгтгэх ажлыг хийж байна. Ийм арга хэмжээнд үр өгөөж муутай татаасыг цөөрүүлэх, агро-ойн аж ахуйг илүү өргөжүүлэх, журам зохицуулалтуудыг уялдуулах, нөхөн сэргээлтийн төслүүдэд жендэрийн болоод залуучуудын оролцоог нэмэгдүүлэх зэрэг хамаарна. Түүнчлэн Монголын Цагаан алт, Шинэ хоршоо-Чинээлэг малчин, Хүнсний аюулгүй байдал, Тэрбум мод зэрэг хөтөлбөрүүдийн хүрээнд уламжлалт мэдлэгийг дамжуулах, үзүүлэх сургуульд-суурилсан сургалтууд зохион байгуулав.

Монгол Улсад 2023 онд есөн аймагт зуд, 179 удаагийн ой хээрийн түймэр, Улаанбаатар хотод хоёр удаагийн томоохон үер зэрэг гамшигт үзэгдлүүд байнга нүүрлэж байгаа нь эрсдэлийг сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх нь зайлшгүй чухал болохыг харуулж байна. Орон нутгийн түвшинд уур амьсгалын мэдрэмжтэй газар, усны нөөцийн менежментийг хэвшүүлснээр орлогын олон эх үүсвэртэй болох, хүн амын эмзэг бүлгүүдийг чадавхжуулах боломж бүрдэнэ.

Монгол Улсын ТХЗ-ын хэрэгжилтийн сайн дурын хоёр дахь удаагийн илтгэлд (VNR) экосистемийг хамгаалахад тус улс ахиц дэвшил гаргаж байгааг онцлон тэмдэглэсэн бөгөөд Нэг Тэрбум Мод кампанит ажил нь ой модыг нөхөн сэргээх, усны нөөцийг хамгаалах ажлыг эрчимжүүлж байна. Түүнчлэн, тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлсэн нь Кунмин-Монреалийн дэлхийн биологийн олон янз байдлын тогтолцооны дагуу 2030 он гэхэд улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 30 хувьд хүргэх зорилттой нийцэж байна. Хэдийгээр ахиц дэвшил гарч байгаа ч сорилт бэрхшээл оршсоор байна. Ялангуяа уур амьсгалын эрсдэлд өртөмтгий, нөөц хомс, байгалийн нөөцийн өгөөж хязгаарлагдмал эмзэг бүлгийн хүн амын хувьд орон нутгийн эрсдэлийг сөрөн тэсвэрлэх чадвар, нийгмийн хамгааллын үйлчилгээний хүртээмжийг эрс сайжруулах шаардлага байна. Мөн гамшгийн эрсдэлийг бууруулах, нөөцийн тогтвортой менежментийн талаарх олон нийтийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэхэд цаашид анхаарах нь чухал байна.

Цаашид Монгол Улс нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хөтөлбөрийнхөө хэрэгжилтийг түргэсгэж, ТХЗ-ын 12 хурдасгуурын нэг болгон байгаль орчны тогтвортой байдлыг үндэсний хөгжлийн тэргүүлэх зорилтуудтайгаа уялдуулах шаардлагатай. Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх НҮБ-ын суурь конвенцийн Талуудын 17-р Бага хурлыг 2026 онд Монгол Улсад зохион байгуулах нь газрын доройтлыг бууруулах, цөлжилтийг сааруулах хүчин чармайлтаа илүү нэмэгдүүлэх боломжийг олгож байна.

Монгол Улсын газар нутгийн 77 хувь нь доройтолд орсон.
©С.Тамир / ОУШХБ



Дасан зохицох чадавхыг сайжруулж, нийгэм, эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах, гамшгийн улмаас нүүлгэн шилжүүлэх эрсдэлийг сааруулахын тулд уур амьсгалын өөрчлөлтөд мэдрэмжтэй хариу арга хэмжээ авах төлөвлөлт, хөгжлийн эрх зүйн зохицуулалтын тогтолцоо бэхжсэн байна.

Хүмүүнлэгийн тусламж:



2023-2024 оны
зудад өртсөн
24,000+
гаруй өрхөд
тусламж хүргэв.

Монгол Улсын нотолгоо мэдээлэл цуглуулах, эрсдэлийн мэдээлэлд суурилж төлөвлөх чадавх нь хэд хэдэн үнэлгээ, судалгааны төслүүдийг хэрэгжүүлсний үр дүнд сайжирсан. Эдгээрээс дурдахад Уур амьсгалын өөрчлөлт, Зудын нийгэм, эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ, Байгаль орчны эрүүл мэндийн судалгааны платформыг хөгжүүлэх, Монголын эмзэг байдлын шинжилгээ, зураглал зэрэг багтсан болно.

Уур амьсгалын эрсдэлийн индекс (CRI)-ийг уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль тогтоомжийн төсөлд тусгасны зэрэгцээ уг индекс нь уур амьсгалын өөрчлөлтийг сөрөн тэсвэрлэх чадавх бэхжүүлэх төлөвлөгөө, уур амьсгалын нөлөөллийг урьдчилан тооцоолох арга зүйн чухал хэрэглүүр болсон. Байгаль орчны эрүүл мэндийн судалгааны платформыг хөгжүүлснээр агаарын бохирдол, ус, ариун цэврийн байгууламж, орон сууц, уур амьсгалын өөрчлөлтийн хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг үнэлэх чадавх ч дээшилсэн. Үүний зэрэгцээ, эмзэг байдлын шинжилгээ хийж, зураглал гаргаснаар эрсдэл өндөртэй газар нутаг, хүн амын бүлгүүдийн талаарх чухал мэдээлэлтэй болж, илүү зорилтот түвшинд бэлэн байдлыг хангах, цаашдын үйл ажиллагааны стратегийг боловсруулж хэрэгжүүлэх боломж бүрдсэн.

Хүмүүнлэгийн хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах хүчин чармайлтыг бэхжүүллээ. Өвөлжилт хүндэрсэн, хаврын салхи шуургатай үед ашиглах өвс, тэжээл

нөөцлөх зориулалтаар есөн агуулах барьсан. Улаанбаатар хотын захын хорооллын оршин суугчдыг үерийн аюулаас хамгаалах зорилгоор үерийн хамгаалалтын хоёр далан барьсан. 2023-2024 оны зудын аюулд нэрвэгдсэн 12400 хүүхэд, 12,000 малчин өрхөд хүмүүнлэгийн тусламж үзүүлсэн.

Агаарын бохирдол, Ус, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуй, уур амьсгалын өөрчлөлт, химийн бодисын аюулгүй байдал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хог хаягдлын менежмент зэрэг байгаль орчны эрсдэлийг шийдвэрлэхэд эрүүл мэндийн асуудлыг нэн тэргүүний зорилт болгон салбар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлсэн. Түүнчлэн Монгол Улс Цар тахалтай тэмцэх сангаас 15.45 сая ам.долларын буцалтгүй тусламжийг авч эрүүл мэндийн онцгой байдлын үед эрт зарлан мэдээлэх систем, лабораторийн чадавх, хүний нөөцийн бэлэн байдлыг сайжруулахад зарцуулав. Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн хүрээний дагуу засгийн газар, орон нутгийн удирдлагууд гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчилж, бүх салбарын уялдаа зохицуулалтыг сайжруулж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлж байна.



НҮБ нь экосистемийн тогтвортой байдлыг хангах, орон нутгийн иргэдийн эрсдэлийг сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэхийн төлөө ажилладаг
©НҮБХХ

Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг тооцсон, газар, ой, биологийн олон янз байдал, ус зэрэг байгалийн нөөцийн тогтвортой менежмент, мал аж ахуйн бүтээгдэхүүний өртгийн сүлжээг сайжруулах, онцгой байдлын үед авах арга хэмжээг үр дүнтэй төлөвлөж зохицуулах зэргээр байгалийн нөөцөөс ихээхэн хамааралтай малчдын нөхөрлөлүүдийн эрсдэлийг даах чадварыг бэхжүүлнэ.



33 сая

га газрын
тогтвортой
менежментийн
төлөвлөгөөг
боловсруулахад
дэмжлэг үзүүлэв.

Монгол Улс дахь НҮБ нь эрсдэлийн мэдээлэл нотолгоонд суурилсан мал аж ахуй, бэлчээрийн менежментийн төлөвлөлтийг уялдуулах үүднээс бүх шатны институцийн чадавхыг бэхжүүлсэн. Богино болон урт хугацааны уур амьсгалын эрсдэлийн загварчлал хийж, эмзэг бүлгийн иргэдийн оролцоог хангасан, сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэхэд чиглэсэн төлөвлөлт хийх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Цаг уур, орчны шинжилгээний газар (ЦУОШГ)-ыг өндөр хүчин чадалтай компьютероор тоноглогосон.

Байгууллагууд, хүн амын бүлгүүд нь эрсдэлийг сөрөн тэсвэрлэх чадвартай, тогтвортой хөдөө аж ахуйн өртгийн сүлжээг бий болгох, мод тарих ажлыг байгальд суурилсан шийдэл болгон хэрэгжүүлэх шинэлэг туршлагыг эзэмшсэн. Эдгээр хүчин чармайлт нь уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлын хомсдол, газрын доройтол зэрэг уур амьсгалын гурвалсан хямралыг даван туулахын зэрэгцээ Монгол Улсын ногоон шилжилтийг урагшлуулахад хувь нэмэр оруулсан.

НҮБ-ын зүгээс 33 сая гаруй га талбайг хамарсан нутаг дэвсгэрийн тогтвортой менежментийн төлөвлөгөөг сум, аймгийн түвшинд боловсруулан хэрэгжүүлэх замаар байгалийн нөөцөөс хамааралтай малчдын бүлгүүдэд дэмжлэг үзүүлсэн. Түүнчлэн зорилтот аймгуудад үхэр, хонины мах, сүү, сүүн бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх төсөлд дэмжлэг үзүүлсэн бөгөөд үүнд 300 гаруй өрх хамрагдсан. Энэ төслийн гол зорилго нь нэг малаас авах ашиг шимийг дээшлүүлэх, малчдын орлогыг нэмэгдүүлэх, малын тоо толгойг бууруулах, бэлчээрийн экосистемийг сайжруулахад чиглэсэн.

НҮБ нь уур амьсгалын хямралыг даван туулах, сөрөн тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлэх шинэлэг, тогтвортой арга туршлагыг дэмждэг.
©С.Тамир / ОУШХБ

Байгалийн нөөцийн тогтвортой менежмент, биологийн олон янз байдлын алдагдлыг бууруулж экосистемийн үйлчилгээг сайжруулах талаар мэргэжлийн мэдлэг чадвартай институтууд, аж ахуйн нэгжүүд, хүн амын бүлгүүд төлөвшсөн, генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашигласнаас гарах ашиг, үр шимийг тэгш, шударгаар хуваалцах, ялангуяа малчдад хүртээмжтэй байх нөхцөл бүрдсэн, чадавх бэхжсэн байна.

Экосистемийн үйлчилгээ буурах, биологийн олон янз байдал алдагдах зэрэгт хүргэж буй хүчин зүйлсийн нийлмэл хүч, харилцан нөлөөллийг тодорхойлж, шийдвэрлэхийн тулд НҮБ-ын системийн байгууллагууд нэгдсэн арга барилаар хандаж, олон нийтийн байгалийн нөөц ашиглах эрхийг хамгаалах чиглэлээр хамтран ажиллаж байна.

Эдгээр нөлөөлөгч хүчин зүйлсийг шийдвэрлэх гол арга зам бол биологийн олон янз байдлын асуудлыг тооцсон газар төлөвлөлт, бэлчээрийн тогтвортой менежментийг дэмжих, бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчдийн амьжиргааг сайжруулах зэргээр хүнсний аюулгүй байдлыг сайжруулах, биологийн олон янз байдлыг нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтийг сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэх юм.

Мөн мал аж ахуйн үйлдвэрлэл, хүнсний хэрэглээний тогтвортой байдлыг нэмэгдүүлэх, газар тариалангийн ургац алдагдлыг багасгах, хувийн хэвшлийн ногоон үйл ажиллагааг дэмжих, байгальд халтай улсын татаас, урамшууллын схемийг хязгаарлахад анхаарал хандуулж байна. Цаашид тогтвортой санхүүжилтийн механизмыг өргөжүүлэх, агро ойн аж ахуйг дэмжих, бодлого, зохицуулалтын уялдааг хангах, засаглалыг бэхжүүлэх, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд жендэрийн

болон залуучуудын оролцоог дэмжих зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

Үзүүлэх сургууль зохион байгуулах, чадавх бэхжүүлэх замаар уламжлалт мэдлэгийг танин мэдэж, дамжуулах нь дээрх хөтөлбөрүүдийн анхаарлын төвд байх болно. НҮБ-аас Монгол Улсын Хөдөө аж ахуйн их сургуулийн Агроэкологийн сургуулийн агроэкологийн арга туршлагыг орон даяар нэвтрүүлж, энэ чиглэлийн сургалтын хөтөлбөрийг боловсруулахад дэмжлэг үзүүлсэн бөгөөд одоогоор мэргэжлийн 13 хөтөлбөрт тусган зааж байна.



НҮБ-аас газрын тогтвортой менежментийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж байна. ©НҮБХХ



Стратегийн тэргүүлэх чиглэл 3: Хүн төвтэй засаглал, эрх зүйт ёс, хүний эрх



Үр дүнгийн зорилт 4:

2027 он гэхэд Монгол Улсын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл явц нь жендэрийн мэдрэмжтэй, оролцоог хангасан, харилцан уялдаатай, нотолгоонд суурилсан, ТХЗ-той уялдсан байж; бүх шатны засаглалын байгууллагууд нь ил тод, хариуцлагатай ажиллаж, хүний эрхийг бүрэн дүүрэн хангаж хамгаалсан, тэгш шударга, эрх зүйт ёсыг хүн бүр, ялангуяа орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүд ялгаваргүй эдлэх боломж нөхцөл бүрдсэн байна.

2024 он бол улс төр, эдийн засаг, нийгмийн томоохон өөрчлөлт гарсан Монгол Улсын хөгжлийн чухал шилжилтийн үе байлаа. 2024 оны долдугаар сард болсон УИХ-ын ээлжит сонгуулиар нийт гишүүдийн тоо 76-аас 126 болж нэмэгдсэний зэрэгцээ УИХ дахь эмэгтэй гишүүдийн хувийн жин 25 хувьд хүрч, Ази, Номхон далайн бүс нутгийн дунджаас давсан онцлог үйл явдал болсон. Мөн энэ удаагийн УИХ-д хөгжлийн бэрхшээлтэй хоёр иргэн, казах үндэстэн эмэгтэй гишүүнээр анх удаа сонгогдсон нь түүхэн үйл явдал болсон юм.

Шинээр байгуулагдсан эвслийн Засгийн газар мөрийн хөтөлбөртөө хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулах, бүс нутгийн хөгжил, боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлтийг нэн тэргүүний зорилт болгож, томоохон 14 төслийг хэрэгжүүлэхээр тууштай ажиллахаа харуулж байна. Гэсэн хэдий ч Монгол Улс нь төрийн албан тушаалтнууд авлигад хамгийн

олноор өртсөн арван орны тоонд багтсан хэвээр байна. Өндөр албан тушаалтнууд болон бизнесийн нэр хүндтэй хүмүүстэй холбоотой хээл хахууль авсан, хөрөнгө мөнгө шамшигдуулсан, татвараас зайлсхийсэн гэх хэргүүд нь боломж хязгаарлагдмал, тэгш бус байдал үргэлжилсээр, байгаль орчин доройтсоор байгаа зэрэгтэй хавсран олон нийтийн дургүйцлийг төрүүлж байна.

Нэмж дурдахад, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам байгуулагдсан нь залуучуудын хөгжилд төрөөс анхаарал хандуулж буйн илэрхийлэл юм.



Залуучуудад хөрөнгө оруулалт хийхийг НҮБ тууштай дэмждэг
©НҮБХАС

Д.Энхжаргал: Өөрчлөлтийн хаалга дотроосоо онгойдог

2024 оны зургаадугаар сард болсон УИХ-ын сонгуулийн үр дүнд Монгол Улсын Их хуралд эмэгтэйчүүдийн төлөөлөл 25.4 хувь болсон нь Азийн дунджаас давж, дэлхийн дундаж болох 26.9 хувьд ойртсон төдийгүй өмнөх сонгуулиас 8.3 хувиар өсөж, Монгол Улсын шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөлөл түүхэн амжилтад хүрлээ.

Олон жилийн турш улс төрийн намууд жендерийн тэнцвэрийг хангах үүрэг хүлээлгүйгээр нэр дэвшигчдээ тодруулж, эмэгтэйчүүдийн улс төр дэх оролцоог хязгаарлаж, шийдвэр гаргах түвшинд хүрэх боломжийг нь хаасаар ирсэн ч 2024 онд Монголын улс төрийн түүхэнд шинэ хуудас нээгдсэн юм.

УИХ-ын сонгуульд нэр дэвшүүлэх хүйсийн квот 20%-иас 30% болж нэмэгдэж, 2028 онд 40% өөлж нэмэгдэхээр хуульчлаад байна. Улс төрийн намууд өмнө нь эмэгтэйчүүдийг сонгуульд нэр дэвшүүлэхийг сонголт гэж хардаг байсан бол одоо хуулиар хүлээсэн үүрэг боллоо.

Үнэндээ эдгээр шинэчлэл нэг өдрийн дотор бий болоогүй юм.

Үнэт зүйл, үзэл санаа, зарчимдаа үнэнч хүмүүс, манлайлагчдын олон жил үргэлжилсэн тууштай хичээл зүтгэл, хүчин чармайлтын үр дүн байсан бөгөөд олон улсын түншүүд болох НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, КОИКА, Швейцарын хөгжлийн агентлаг зэрэг байгууллагуудын урт хугацааны тасралтгүй дэмжлэг чухал нөлөө үзүүлээ.

Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлсэн төслийн хүрээнд эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах үндэсний эвсэл болох МОНФЕМНЕТ нь хоёр сонгууль дамнан олон зуун эмэгтэй удирдагчийг сургаж бэлтгэсэн. Түүнчлэн, 2021 онд “МОНФЕМНЕТ Үндэсний сүлжээ” болон “Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд” ТББ хамтран эмэгтэйчүүдийн манлайллыг бэхжүүлж, улс төр дэх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсад анх удаа Эмэгтэйчүүдийн Манлайллын Сүлжээг байгуулжээ. Тус сүлжээ улс даяар эмэгтэйчүүдийн манлайллыг бэхжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэн дэмжлэг үзүүлсээр өнөөдөр 3,000 гаруй манлайлагч эмэгтэйг нэгтгэсэн Үндэсний хөдөлгөөн болтлоо өргөжиж байна.

20 гаруй жил энэ замнал, дуу хоолой, манлайлал, хамтын түншлэлийн тэргүүн эгнээнд явсан олон тод төлөөлөл дунд МОНФЕМНЕТ Үндэсний сүлжээний Ерөнхий зохицуулагч Д. Энхжаргал байсаар ирэв. Тэрээр эзэмшсэн эрхзүйч мэргэжлээрээ ажил амьдралын гараагаа эхэлсэн ч төд удалгүй иргэний нийгэмд хүчин зүтгэх болж, жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг хамгааллыг бэхжүүлэх, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх, хүйсийн квот тогтооход чухал үүрэг гүйцэтгэсээр иржээ.

Тууштай зүтгэл, тогтвортой дэмжлэгтэйгээр юунд хүрч болдгийг энэхүү ахиц дэвшлээс тодхон харах боломжтой. Тэмцэл дуусаагүй—Энэ хөдөлгөөнийг зогсоох боломжгүй. Одоо бид бүхний үүрэг бол энэ эрч хүчээ суллахгүй, таслахгүй байх явдал юм.

Жендерийн тэгш байдал, хүний
эрхийн манлайлагч Д.Энхжаргал
©НҮБХХ

Жендэрийн эрх тэгш байдал, хөдөлмөрлөх эрх зэрэг асуудлаар хүн амын эмзэг хэсгийн эрхийг хамгаалах, дэмжих, хяналт тавих эрх үүрэг бүхий шүүх засаглалын байгууллагууд, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, иргэний нийгмийн байгууллагуудын чадавх сайжирна.

Хөдөлмөрлөх эрхийг дэмжих нь:



200+

хүн сургалтад хамрагдсан



2,322

хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст олгох орон сууцны 5%-ийн квотыг 15% хүртэл нэмэгдүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэв.

НҮБ-аас Монгол Улсад хүний эрхийн механизмыг бэхжүүлэх чиглэлээр үзүүлж ирсэн дэмжлэгээ 2024 онд тасралтгүй үргэлжлүүлж, институцийн болон бодлогын бодит үр дүнд хүрсэн. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК)-д техникийн туслалцаа үзүүлснээр Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах болон Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын үр нөлөөг дээшлүүлэв. ХЭҮК-ын хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих, хамгаалах чадавхыг бэхжүүлэх, хамтарсан санхүүжилт татах, мэргэжлийн туслалцаа үзүүлэх хамтын ажиллагаа бэхжиж байна. НҮБ-ын Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны гишүүд 2024 оны 5-р сард Монгол Улсад айлчилсан бөгөөд айлчлалын үр дүнд цагдан хорих нөхцөлийг сайжруулах тодорхой зөвлөмжүүд өгсөн. Цаашлаад, НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо мөн оны 11 дүгээр сард Монгол Улсын илгээсэн тус конвенцийн хэрэгжилтийн тайланг хэлэлцээд гаргасан дүгнэлт, зөвлөмждөө, тус улсад байцаалт явуулж буй байруудад хяналтын системийг нэвтрүүлэх чиглэлээр ахиц дэвшил гарч буйг тэмдэглээд, цаашид сайжруулах шаардлагатай чиглэлүүдийг тодорхойлж зөвлөмж гаргасан. Мөн НҮБ-ын зүгээс албадан нүүлгэн шилжүүлэлтийн эсрэг стратеги төлөвлөгөө боловсруулах, бэлэн байдлыг хангах чиглэлээр техникийн туслалцаа үзүүлсэн байна.

Үүний зэрэгцээ хөдөлмөрлөх эрхийг хангах чиглэлээр НҮБ нь Засгийн газартай нягт хамтран ажиллалаа. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын (ОУХБ) 81, 129 дүгээр конвенцийг соёрхон батлах тухай үзэл баримтлалыг батлах, Ажлын байран дахь хүчирхийлэл, хөдөлмөрийн аюулгүй байдлын асуудлаарх 190, 187 дугаар конвенцийг соёрхон батлах талаарх мэргэжлийн удирдамжаар хангаж ажиллалаа. Чадавх бэхжүүлэх үйл ажиллагаанд шүүгч, прокурор, цагдаа, сэтгүүлч, ажил олгогч, үйлдвэрчний эвлэлийн удирдлагууд зэрэг 200 гаруй оролцогч тал хамрагдсан. Энэ хүрээнд албадан хөдөлмөр эрхлэх эрсдэл өндөртэй 1231 хүнийг оролцуулаад нийт 2322 хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн.

Эмзэг бүлгийн хүн амыг дэмжихэд чиглэсэн бодлогын нөлөөллийн ажлууд мөн зохих үр дүнд хүрч байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зохистой орон байрны хүртээмжийг сайжруулах зорилго бүхий үндэсний хөтөлбөрийг батлах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд орон сууц олгох 5 хувийн квотыг 15 хувь болгож нэмэгдүүлэхэд НҮБ-ын оролцоо чухал үүрэг гүйцэтгэсэн болно. Түүнчлэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох боломжийг сайжруулах чиглэлээр бодлого боловсруулан ажиллаж байна.

Харааны бэрхшээлтэй хүмүүсийн төлөөлөл болох ноён Батцэнгэл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй хүртээмжтэй боловсрол, цахим шилжилтийг хүчтэй дэмжигч юм. © НҮБСЗГ



Бодлогын үнэлгээг тогтмол хийх, нөлөөлөл, сурталчилгаа, сургалт мэдээллийн үйл ажиллагааг өргөжүүлэх зэргээр эмэгтэйчүүд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эсрэг хүчирхийлэл, дарамт шахалт, хүн худалдаалах гэмт хэрэг зэргээс үр дүнтэй урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, жендэрийн эрх тэгш байдлыг хангах механизм, үйл явцыг сайжруулна.

Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь:



16

хоногийн ЖСХ-тэй тэмцэх нөлөөллийн аяны үр дүнд



1.2 сая

хүнд хүрч ажиллав.

Монгол Улсын Засгийн газар НҮБ-ын системийн байгууллагуудтай хамтран 2024 оны 8 дугаар сард Дэлхийн эмэгтэйчүүдийн чуулга уулзалтыг зохион байгуулж жендэрийн тэгш байдлыг хангахын төлөө тууштай байгаагаа нотлон харуулсан. Тус чуулга уулзалтад дэлхийн 19 орны өндөр түвшний эмэгтэй удирдагчид, НҮБ-ын системийн 20 гаруй байгууллага, олон улсын байгууллагуудын удирдах албан тушаалтнууд оролцож, дэлхий дахинаа байгальд ээлтэй, сайн сайхан ирээдүйг бүтээн байгуулахад эмэгтэйчүүдэд тулгарч буй сорилт бэрхшээл, боломжийн талаар хэлэлцсэн.

НҮБ-аас Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, тогтолцооны хариуцлагыг тодорхой болгох, эрүүл мэнд, хууль эрх зүй, боловсролын салбарын уялдаа зохицуулалтыг бэхжүүлэх чиглэлээр дэмжлэг үзүүлсэн. Түүнчлэн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор стандарт үйл ажиллагааны 13 журмыг (13 SOPs) боловсруулсны зэрэгцээ захиргааны мэдээлэл цуглуулах ажлыг сайжруулах, хүүхэд хамгааллын үйлчилгээг бэхжүүлэхэд анхаарч ажиллалаа.

Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх талаар олон нийтийн ойлголт мэдлэг, хариуцлагыг нэмэгдүүлэх зорилго агуулсан 16 хоногийн кампант ажил зохион байгуулж 1.2 сая гаруй хүнд хүрч ажиллахад НҮБ-ын оролцоо чухал үүрэг гүйцэтгэсэн. Хүчирхийллийн шинээр гарч ирж буй хэлбэрүүдийг шийдвэрлэх, Технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан

хүчирхийлэлтэй тэмцэх талаар үндэсний яриа хэлэлцүүлэг өрнүүлэх, шинэлэг, олон нийтэд суурилсан гүйцэтгэлийн арга техникийг турших зэргээр жендэрийн мэдрэмжтэй бодлого боловсруулахад хувь нэмэр оруулсан.

Үндэсний жендэрийн шинжээчдийн зөвлөлийг 30 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, албан хаагчдад зориулсан жендэрийн зорилтот сургалт, жендэрийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх сургалт семинар зохион байгуулснаар интитүцийн чадавх мэдэгдэхүйц сайжирсан. Эдгээр арга хэмжээ нь үндэсний болон орон нутгийн түвшинд жендэрийн мэдрэмжтэй засаглалыг бэхжүүлэх үндэс суурийг тавьсан. Шинжлэх ухаан, инженерчлэл, математик, технологи (ШИМТ)-ийн чиглэлийн хөдөлмөр эрхлэгчдийн жендэрийн ялгааг арилгах үүднээс “Уул уурхайн салбарын ШИМТ эмэгтэйчүүд” кампанит аян зохион байгуулж, 1200 гаруй эмэгтэйчүүдийг чадавхжуулж, уламжлалт бус салбар дахь тэдний оролцоог дэмжихэд НҮБ хүчин чармайлт гаргасан.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлд НҮБ-ын дэмжлэгтэйгээр зургаан хохирогчдод тусламж үйлчилгээ үзүүлж, сургалтын хөтөлбөр шинэчлэх, тусгай тоног төхөөрөмж авах, холбогдох мэргэжилтнүүдийг бүс нутгийн чуулга уулзалтад оролцоулах зэргээр Монгол Улсын хууль сахиулах албаны чадавхыг бэхжүүлсэн. Нээлттэй эх сурвалжийн тагнуулын арга техникийг ашиглан кибер гэмт хэрэг мөрдөн шалгах чадавхыг сайжруулсан.

Дэлхийн эмэгтэйчүүдийн чуулга уулзалтын үеэр НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч, хатагтай Амина Ж.Мохамед олон улсын хамтын нийгэмлэгт хандан дэлхийн хэмжээний бүхий л асуудалд жендэрийн тэгш байдлыг хангахыг тэргүүлэх зорилт болгохын төлөө нэгдэхийг уриалав. Зураг дээр: Дэлхийн эмэгтэйчүүдийн чуулга уулзалт (WWF 2024)-ын өндөр түвшний төлөөлөгчид Монгол Улсын Ерөнхийлөгчийн хамт ©НҮБСЗГ



Төв, орон нутгийн оролцогч талуудын үйлчилгээг ил тод, хүн төвтэй, үр нөлөө гарахуйцаар үр дүнтэй хүргэх чадавх дижитал хувьсалд шилжсэнээр сайжирч; нотолгоонд суурилж бодлого боловсруулах, хяналт шинжилгээ хийх, тайлагнах үйл явцыг харилцан уялдуулж; бодлого шийдвэр гаргахад иргэд оролцох боломжийг бүрдүүлснээр тэд эрх баригчдаас үр дүнгийн хариуцлага нэхэх чадвар эзэмшсэн байна.

Хүүхдийн эрхийг хамгаалах нөлөөллийн үр дүнд



Монгол Улсын хүүхэд хамгааллын төсөв 2025 онд

20.8

тэрбумд хүрч өсөв.

НҮБ нь 2024 онд үр дүнд суурилж үндэсний нэгдсэн төлөвлөгөө, төсөв боловсруулах төрийн байгууллагуудын чадавхыг сайжруулах замаар Монгол Улсын засаглалын тогтолцоог бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллав. Үр дүнд суурилсан төсөв (RBB) боловсруулахад зориулсан аргачилсан удирдамж, цахим арга хэрэгсэл, платформыг хөгжүүлснээр төв, орон нутгийн түвшинд ил тод байдал, хариуцлага дээшилж байна. НҮБ-ын дэмжлэгтэйгээр 2025 оны улсын төсвийн төслийг боловсруулахдаа үр дүнд суурилсан төсөв боловсруулах удирдамжийг дагаж мөрдөн, улсын төсвийн хөрөнгийг илүү үр ашигтай, тэгш хуваарилах боломж бүрдсэн.

НҮБ-ын дэмжлэгтэйгээр Дэлхийн зэрлэг ан амьтдыг хамгаалах сан (WWF)-гийн "EQUANOMICS" хөтөлбөрийн хүрээнд жендэрийн мэдрэмжтэй татвар, санхүүжилтийн төлөвлөгөө боловсруулах замаар төр, хувийн хэвшлийн санхүүжилтийг жендэрийн тэгш байдлыг хангах зорилтуудтай уялдуулахад томоохон ахиц гарсан. Үүний зэрэгцээ НҮБ ирээдүйг харсан хөгжлийн хувилбаруудыг боловсруулахад дэмжлэг үзүүлж, Ирээдүйн шаардлагад нийцэх засаглалын асуудлаарх өндөр түвшний бодлогын яриа хэлэлцүүлэг өрнүүлэхийг дэмжих замаар Монгол Улсын ногоон шилжилтийн хөтөлбөрийг урагшлуулахад хувь нэмэр орууллаа. Эдгээр хувилбарууд нь Монгол Улсын Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхээр дэвшүүлсэн зорилттой уялдуулсан нүүрсхүчлийн хийн ялгаруулалтыг бууруулах урт хугацааны стратегийг боловсруулах үндэслэл болно.

Мөн НҮБ-ын нөлөөлөл, сурталчилгааны ажлын үр дүнд Монгол Улсын хүүхэд хамгааллын төсөв 2024 онд 14 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 20.8 тэрбум төгрөг болж 1.5 дахин нэмэгдэж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үзүүлэх үйлчилгээ өргөжиж, сургуулийн сурагчдын хоолны хөтөлбөрийн чанарт ахиц гарлаа.

Авлигатай тэмцэх газар (АТГ), эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх албад, прокурор, санхүүгийн зохицуулах байгууллагуудын ажилтнуудад зориулсан төрөлжсөн сургалтыг зохион байгуулж, тэдний санхүүгийн мөрдөн шалгалт хийх, хөрөнгө орлогын мэдүүлгийг шалгах ур чадварыг дээшлүүлсэн. Ил тод байдал, иргэдийн оролцоог хангасан сургалт семинар зохион байгуулж иргэний нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлсэн.

Тоон мэдээллийн хувьд НҮБ-ын дэмжлэгтэйгээр Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа хийснээр Монгол Улсад хөгжлийн 150 гаруй үзүүлэлтийг, түүний дотор ТХЗ-ын 40 үзүүлэлтийг хүйсээр задлан тайлагнах боломж бүрдсэн. Түүнчлэн 2025 онд явуулах Хүн амын завсрын тооллогын бэлтгэл ажил, гэмт хэргийн статистикийн шинэ ангилал, Монгол Улсын анхны жендэр, байгаль орчны судалгаа зэрэг ажлыг хийснээр мэдээлэлд суурилсан бодлого боловсруулах боломж улам сайжирсан.

Хүмүүнлэгийн тусламжийн арга хэмжээний хүрээнд, НҮБ нь 1.05 сая ам.долларын хөрөнгийг татан төвлөрүүлж, зудад нэрвэгдсэн 17 аймгийн 27840 иргэнд тусламж үзүүлж, хот орчмын оршин суугчдад үерийн аюулаас хамгаалах ажлын төлөвлөлтөд оролцох чадавхыг сайжруулсан.

НҮБ-аас мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжөөр хангах, тоон бичиг үсгийн сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, хиймэл оюун ухааны (AI) ландшафтын үнэлгээ хийх, кибер аюулгүй байдлын талаарх сурталчилгааны кампанит ажил зохион байгуулах зэрэг чиглэлээр дэмжлэг үзүүлж Монгол Улсын цахим шилжилтэд хувь нэмэр орууллаа. Хэвлэл мэдээллийн 120 гаруй мэргэжилтэн, удирдах ажилтнуудын чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлж, эмзэг бүлгийн суралцагчдыг мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмж, интернетээр хангах замаар цахим сургалтын тасралтгүй байдлыг хангасан.

НҮБ нь хүүхдийн сайн сайхны төлөө хөрөнгө оруулахыг байнга уриалдаг. Энэхүү хөрөнгө оруулалтын 1.30 ам долларын эдийн засгийн өгөөж нь 2.50 ам.долларт хүрдгийг онцолж байна. ©НҮБХС

Иргэний нийгэм, залуучуудын зөвлөлүүд, эмэгтэйчүүд, залуучуудын сүлжээдээр дамжуулан улсын болоод орон нутгийн хурлын сонгуулиуд, орон нутгийн бодлого шийдвэр гаргадаг байгууллагуудын эмэгтэйчүүд, залуучуудын төлөөлөл, оролцоог нэмэгдүүлнэ.

Эмэгтэйчүүдийн манлайллын сүлжээг бэхжүүлснээр



1,878

эмэгтэй үр шимийг нь хүртэв.



Тэдний

8

нь УИХ-ын гишүүнээр сонгогдов.



Залуучуудын хөгжлийг дэмжих хуулийн төсөл, стратегид

40,000+

гаруй залуусын дуу хоолой, оролцоог хангав.

2024 онд НҮБ-ын олон талын дэмжлэгтэйгээр Монгол Улс нь жендэрийн тэгш байдлыг хангах, Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдэгдэхүйц ахиц дэвшил гаргасан. УИХ-ын ээлжилт сонгуулиар УИХ дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл 25.4 хувь (17.1%) болж өссөн нь бүс нутгийн дундаж үзүүлэлтээс давж эмэгтэйчүүдийн манлайлалд хандах нийгмийн хандлага өөрчлөгдсөнийг илэрхийлсэн онцлог үйл явдал болсон.

Эмэгтэйчүүдийн манлайллын сүлжээний тусламжтайгаар 1878 эмэгтэйг чадавхжуулахад НҮБ чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд тэдний 58 нь УИХ-д нэрээ дэвшүүлж 8 нь гишүүнээр сонгогдсон байна. Жендэрийн талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөөр олон нийтэд чиглэсэн кампанит ажил зохион байгуулсан нь 1.2 сая орчим хүнд хүрч, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны талаар илүү эерэг үзэл бодлыг олон нийтийн дунд бий болгосон. Үүний урт хугацааны үр нөлөөг хадгалахын тулд жендэрийн асуудлыг үндэсний хэмжээнд хөхиүлэн дэмжих жендэрийн мэргэжилтнүүдийн үндэсний хүчирхэг сүлжээг бий болгоход НҮБ дэмжлэг үзүүлж байна.

Залуучуудыг чадавхжуулах чиглэлд мөн ахиц дэвшил гарч байна. Залуучуудын (15-34) нөхцөл байдлын дүн шинжилгээний үр дүн нь 2024 оны Ирээдүйн асуудлаарх дээд хэмжээний чуулга уулзалт, 2024 онд НҮБ анх байгуулагдсан тэмдэглэлт өдрөөр зохион

байгуулсан яриа хэлэлцүүлэгт нөлөөлсөн төдийгүй ТХЗ-ын төлөөх залуучуудын манлайлал нэн чухал болохыг нотолж, Монгол Улсын хөгжлийн бодлогыг боловсруулахад чухал ач холбогдолтой мэдээлэл болсон.

НҮБ-ын дэмжлэгтэйгээр залуучуудын сэтгэцийн эрүүл мэнд, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх үйл ажиллагаа, манлайлал зэрэг асуудлаар БНХАУ, Кени Улстай мэдлэг туршлага солилцож, хамтын ажиллагааг сайжруулав. Түүнчлэн 40 мянга гаруй залуусыг зөвлөлдөх уулзалтуудад татан оролцуулсан нь Залуучуудын хөгжлийг дэмжих хуулийг шинэчлэн найруулах, 2025 оныг “Залуучуудын жил” болгон зарлахад нөлөөлсөн бөгөөд залуучуудын манлайлж буй санаачлагыг илүүтэй дэмжиж, санхүүжилт олгож байна.

НҮБ нь Шинжлэх ухаан, инженерчлэл, математик, технологи (ШИМТ)-ийн хөтөлбөрүүдэд жендэрийн ялгаатай байдлын талаарх ойлголт мэдлэгийг сайжруулах, үүнд чиглэсэн үйл ажиллагааг дэмжин идэвхжүүлж байна. ШИМТ-ийн чиглэлээр ажиллах, суралцахад нь эмэгтэйчүүд, охидод урам зориг өгөх, чадавхжуулах зорилгоор #STEM4ALL, Playtime наадам, “Уул уурхайн салбарт манлайлж буй ШИМТ эмэгтэйчүүд” зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.



Хилийн чанад дахь монголчууд 2024 оны УИХ-ын сонгуульд идэвхтэй оролцож, сонгох эрхээ хэрэгжүүлэв. ©ОУШХБ

2.3 Түншлэл, Тогтвортой хөгжил 2030 хөтөлбөрийн санхүүжилтийг дэмжих

Засгийн газартай хамтран ажиллах:

Монгол Улс дахь НҮБ нь ТХЗ-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх болон 2023-2027 онд хэрэгжүүлэх НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ (ТХХАХ)-г хэрэгжүүлэхэд Монгол Улсын Засгийн газартай стратегийн түншийн хувьд нягт хамтран ажиллаж байна. 2024 онд болсон Ирээдүйн асуудлаарх дээд хэмжээний чуулга уулзалтад бэлтгэж оролцогч талуудтай өргөн хүрээний хэлэлцүүлэг өрнүүлэх, дэлхийн түвшинд яриа хэлэлцүүлэгт оролцох зэрэгт нь Засгийн газарт НҮБ дэмжлэг үзүүлж ажиллалаа. Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын системийн байгууллагууд хамтран Дэлхийн эмэгтэйчүүдийн чуулга уулзалтыг Монгол Улсад зохион байгуулж, оролцогч олон талуудыг нэгтгэн жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийг чадавхжуулах, эмэгтэйчүүдэд тулгарч буй сорилт бэрхшээлийг шийдвэрлэх арга замын талаар хэлэлцлээ.

Түүнчлэн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо, ХААН Банк, Монгол Улс дахь НҮБ болон олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр Гурав дахь удаагийн Монголын тогтвортой санхүүгийн форум-ыг зохион байгуулсан нь Монгол Улсын ногоон, хүртээмжтэй хөгжлийг дэмжиж тогтвортой санхүүжилт, хөрөнгө оруулалт хийх амлалтыг бататгалаа. Монгол Улсын Засгийн газар “Бүсчилсэн хөгжлийн форум”-ыг зохион байгуулахад Монгол Улс дахь НҮБ дэмжлэг үзүүлсэн бөгөөд энэ форумгаар Засгийн газраас ирэх дөрвөн жилд хэрэгжүүлэх Үйл ажиллагааны хөтөлбөрийг танилцуулсан. Тус хөтөлбөрийн тэргүүлэх дөрвөн чиглэлийн нэг нь бүсчилсэн хөгжлийг дэмжих юм.



Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ, НҮБ анх байгуулагдсан тэмдэглэлт өдөр Монгол Улс дахь НҮБ-ын Удирдлагын багийнхантай дурсамжийн зураг селфидэж байгаа нь. ©НҮБСЗГ

Хөгжлийн түншүүдтэй хамтран ажиллах:

Монгол Улс дахь НҮБ нь 2024 онд Хөгжлийн түншүүдийн бүлэг болон түүний сэдэвчилсэн ажлын хэсгүүдээр дамжуулан хамтын ажиллагаагаа улам бэхжүүлж ажиллалаа. Цахим хөгжлийн ажлын хэсгийг албан ёсоор байгуулж, хөгжлийн гол түншүүдтэй хамтран Монгол Улсын цахим хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ахиц дэвшил гаргасан. Мөн тогтвортой хөгжлийн төлөөх хариуцлагатай хөрөнгө оруулалт, санхүүжилтийн талаарх бодлогын яриа хэлэлцүүлгийг дэмжих Тогтвортой санхүүжилтийн ажлын хэсгийг шинээр байгуулав. Үүний зэрэгцээ, Эрчим хүчний ажлын хэсэг нь тарифын шинэчлэлийн хэлэлцүүлгийг зохицуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд холбогдох хөгжлийн түншүүд болон төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг илүү тогтвортой, эрсдэлийг сөрөн тэсвэрлэх чадвартай эрчим хүчний салбарын стратегитай уялдуулж байна.

НҮБ-ын ТХХАХ-г хэрэгжүүлэх хамтын ажиллагааг өргөжүүлж, шаардагдаж байгаа санхүүжилтийг татан төвлөрүүлэхийн тулд Монгол Улс дахь НҮБ нь 2025-2027 онд хэрэгжүүлэх Түншлэл, хөрөнгө татан төвлөрүүлэх стратеги (PRMS) боловсруулсан. Энэхүү стратеги нь олон талт түншлэлийг (MSPs) дэмжиж, ТХЗ-ын хэрэгжилтийг хурдасгах замын зураглал болж өгнө. Бидний нийтлэг мөрийн хөтөлбөр, НҮБ 2.0, Санхүүжилтийн компакт гэрээ зэрэг дэлхий дахинаа мөрдөж буй хөтөлбөрүүдэд тулгуурлан Түншлэл, хөрөнгө татан төвлөрүүлэх стратеги (PRMS)-ийн хүрээнд олон талт түншлэлийг бэхжүүлэх, Монголын нөхцөлд хөрөнгө нөөц дайчлах стратегийг боловсруулна.

Олон улсын болон үндэсний хүмүүнлэгийн байгууллагуудтай хамтран ажиллах:

НҮБ-ын Суурин зохицуулагч нь гамшгийн бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авахад Монгол Улсын Засгийн газарт дэмжлэг үзүүлэх зорилгоор байгуулагдсан олон улсын болон үндэсний хүмүүнлэгийн байгууллагуудаас бүрдсэн Хүмүүнлэгийн тусламжийн баг (ХТБ)-ийг тэргүүлнэ. 2023-2024 оны өвөлжилт эрс хүндэрч зуд болох үед ХТБ нь Засгийн газартай нягт хамтран ажиллаж, хөрөнгө нөөц татан төвлөрүүлж, яаралтай тусламжийн арга хэмжээг хэрэгжүүлж эмзэг бүлгийн хүн

амыг хамгаалах арга хэмжээ авсан. НҮБ-ын сиситемийн байгууллагууд, Монголын Улаан Загалмай Нийгэмлэг, Хүүхдийг Ивээх Сан, АДРА Монгол ОУБ, Гүүд Нейборс, Дэлхийн Зөн Монгол ОУБ, Пийпл Ин Нийд болон бусад хүмүүнлэгийн түншүүд нягт хамтран ажиллаж гамшигт хамгийн ихээр нэрвэгдсэн малчдын амь насыг аврах тусламж үзүүлж, Монгол даяар эрсдэлийг сөрөн тэсвэрлэх чадавхыг сайжруулах урт хугацааны хөтөлбөрүүдийг дэмжиж ажилласан.

Хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллах:

ТХЗ-уудыг бүрэн хэрэгжүүлэхэд олон талт хамтын ажиллагаа маш чухал хэвээр бөгөөд Монгол Улс дахь НҮБ хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллагуудтай нягт хамтран ажиллаж байна. МҮХАҮТ-ын Бизнесийн ёс зүйн төвтэй хамтран 2024 оны 10 сард НҮБ анх байгуулагдсан тэмдэглэлт өдрийг тохиолдуулан бизнесийн ёс зүйтэй үйл ажиллагаа, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжихэд хувийн хэвшлийн гүйцэтгэх үүргийг онцолж, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг чадавхжуулах, зах зээлд нэвтрэх, харилцаа холбоо тогтоох, мэдлэгээ хуваалцахад дэмжлэг үзүүлэх асуудлаар өндөр түвшний хэлэлцүүлгийг зохион

байгуулсан. Түүнчлэн, их, дээд сургууль, судалгааны байгууллагуудтай хамтран ажиллаж тогтвортой хөгжлийн талаар мэдлэг солилцох, инноваци, хамтын ажиллагааны шинэ боломжийг бий болгоход дэмжлэг үзүүлж байна. Тухайлбал, Монгол Улс дахь НҮБ нь Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын Олон улсын судалгааны төвтэй хамтарсан тунхаглалд гарын үсэг зурж, далайд гарцгүй орнуудын өмнө тулгарч буй хөгжлийн өвөрмөц сорилтуудыг шийдвэрлэхэд чиглэсэн бодлогын судалгаа, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна.



Тогтвортой, хүртээмжтэй хөгжлийн төлөө хувийн хэвшлийн түншлэл өндөр түвшний форум ©НҮБСЗГ

Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах:

Монгол Улс дахь НҮБ нь үндэсний болон олон улсын бодлогын яриа хэлэлцүүлэгт олон талын үзэл бодлыг сонсох, тусгах зорилгоор иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ)-тай идэвхтэй хамтран ажиллаж байна. Тухайлбал, Монгол Улс Ирээдүйн асуудлаарх дээд хэмжээний чуулга уулзалтад бэлтгэхэд зориулсан зөвлөлдөх уулзалтууд нь Монгол Улсын хөгжлийн стратегийн алсын харааг тодорхойлоход ИНБ-ууд хувь нэмрээ оруулах хүртээмжтэй платформ болсон юм. ИНБ-ууд Хөгжлийн түншүүдийн бүлэг болон түүний сэдэвчилсэн ажлын хэсгүүдийн шат шатны уулзалтуудад идэвхтэй оролцож, бодлогын

хэлэлцүүлгүүдэд хувь нэмрээ оруулж, тогтвортой хөгжлийн олон талт оролцоог хангахад дэмжлэг болсон.

Эдгээр түншлэлээр дамжуулан Монгол Улс дахь НҮБ нь 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хурдасгах, хүн бүрийн эрх ашигт нийцсэн тогтвортой хөгжилд хүрэхийн тулд салбар хоорондын хамтын ажиллагааг дэмжиж ажилласаар байх болно.



Ирээдүйн асуудлаарх дээд хэмжээний чуулга уулзалтад бэлтгэж зохион байгуулсан зөвлөлдөх уулзалтад оролцож байгаа талууд. 2024 оны 9-р сар ©НҮБСЗГ

2.4 НҮБ-ын нэгдмэл хамтын ажиллагааны үр дүн: НҮБ-ын үйл ажиллагааны харилцан уялдаа, үр дүн, нөлөө

2024 он бол НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ баримт бичгийн хэрэгжилтийн хоёр дахь жил юм. Тайлант жил Монгол Улс дахь НҮБ-ын хувьд Монгол Улсын Засгийн газартай нягт хамтран ажиллаж, бүс нутгийн хөгжил, хүний хөгжил, эдийн засгийн бодлого, засаглал зэрэгт анхаарлаа төвлөрүүлж, улс орны хөгжлийн тэргүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн чухал үе байлаа. Монгол улсын хөгжлийн стратегид тодорхойлсон тэргүүлэх чиглэлүүд нь НҮБ-ын ТХХАХ-ний стратегийн зорилтуудтай шууд уялдаж байгаа нь бидний бүхий л хүчин чармайлт уялдаа холбоотой, үр дүнтэй байх боломжийг олгож байна.

2024 онд тэгш хүртээмжтэй эрчим хүчний шилжилтийг хурдасгах, цахим E-Mongolia үйлчилгээг бэхжүүлэх гэсэн хоёр үндсэн чиглэлд хамтын хүчин чармайлт гаргасан нь НҮБ нь засгийн газрын стратегийн зорилтуудтай нийцсэн бодит үр дүнд хүрэх чадвартайг харуулж байна. Эдгээр хамтарсан хөтөлбөрүүд нь Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй эдийн засгийн болоод засаглалын шинэчлэлийг дэмжээд зогсохгүй үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, Монгол орон даяар цахим шилжилтийг дэмжихэд чухал хувь нэмэр оруулсан.

Монгол Улс 2023-2024 оны өвөл сүүлийн тавин жилд тохиосон хамгийн хатуу ширүүн өвөлтэй нүүр тулж, зудын улмаас 8.1 сая гаруй толгой мал хорогдож, малчдын амьжиргааг сүйрүүлсэн. НҮБ-ын Суурин зохицуулагчийн удирдлага дор НҮБ-ын Хүмүүнлэгийн тусламжийн Удирдлагын баг шуурхай арга хэмжээ авсны үр дүнд 10.6 сая ам.долларын хөрөнгийг татан төвлөрүүлсний зэрэгцээ гамшигт нэрвэгдсэн 66,685 хүнд тусламж үзүүлсэн. Энэхүү хариу арга хэмжээг хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуй, боловсрол, эрүүл мэнд, хоол тэжээл, ус, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуй, нийгмийн хамгаалал зэрэг олон салбарын оролцоотойгоор зохицуулсан нь НҮБ олон талын хэрэгцээг хангахын тулд салбар бүртэй илүү үр дүнтэй хамтран ажиллах чадвартайг харуулсан.

Түүнчлэн НҮБ-ын системийн байгууллагууд Монгол Улсын Засгийн газартай нягт хамтран ажиллаж, тогтвортой амьжиргааг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэж цаашид тулгарч болзошгүй сорилтод малчдыг бэлэн, бэлтгэлтэй байх чадварыг эзэмшүүлэх зорилго бүхий Шинэ хоршоо санаачилгыг дэмжиж ажилласан. Зудын гамшигтай

тэмцэх НҮБ-ын олон салбарын оролцоотой хамтарсан арга барил нь хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалттай, цогц шинэ стандартыг тогтоосон.

Монгол Улс дахь НҮБ нь 2024 оны туршид Тогтвортой хөгжлийн хөтөлбөр болон “Хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмыг бодитоор хэрэгжүүлэхийн тулд тогтвортой хөгжлийн төлөөх мэдээлэл харилцаа, нөлөөллийн үр дүнтэй ажлуудаа тууштай хэрэгжүүллээ. Монгол орны хойд хязгаарт алслагдсан Тайгын бүс нутагт цаа буга маллан амьдарч буй цаатан иргэдийн отогт НҮБ-ын Суурин зохицуулагч зочилсон нь түүхэн алхам болсон юм. Төв суурингаас мянга гаруй километрийн алсад тусгаарлагдсан цаатан овгийнхон нийгмийн суурь үйлчилгээ авах боломжоор тун хязгаарлагдмал байна. Цаатан хүүхдүүдийн чанартай боловсрол эзэмших эрхийг хамгаалах, юуны түрүүнд сургуулийн дотуур байрны нөхцөлийг яаралтай сайжруулахыг Суурин зохицуулагч холбогдох байгууллагуудад хандан уриалсан билээ.

Монгол Улс дахь НҮБ нь Бизнесийн үйл ажиллагааны стратеги (БҮАС)-ийн дагуу уялдааг хангах дотоод зохицуулалт, үйл ажиллагааныхаа үр ашгийг бэхжүүлж байна. 2024 онд БҮАС-т үнэлгээ хийж нийтлэг үйлчилгээний тоог 10-аас 17 болгож нэмэгдүүлсэн нь үйл ажиллагааг оновчтой болгож, НҮБ-ын системийн байгууллагуудын хамтын нөлөөг нэмэгдүүлэх алхам болсон. 2019-2024 онд БҮАС 497,651 ам. долларын хэмнэлт, үр ашиг гаргасан нь НҮБ нь ТХЗ-уудыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ үйл ажиллагааныхаа үр ашгийг дээшлүүлэх амлалтаа биелүүлж байгааг харуулж байна.

НҮБ нь 2024 онд Монгол Улсын Засгийн газар болон бусад оролцогч талуудтай амжилттай хамтран ажилласан нь тогтвортой хөгжлийн зорилгуудад хүрэхийн тулд нягт хамтын ажиллагаа нэн чухал болохыг дахин бататгаж байна. НҮБ-ын системийн хэмжээнд үр дүнтэй зохицуулалт хийснээр хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, урт хугацааны хөгжлийн зорилтоо хэрэгжүүлэхийн аль алинд мэдэгдэхүйц дэвшил гаргасан нь НҮБ-ын үйл ажиллагааны уялдаа, үр нөлөө, үр дүнгийн ахицыг харуулж байна. НҮБ нь Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлого-Алсын хараа 2050, 2030 оны Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хэнийг ч орхигдуулахгүй байх чиг үүргээ тууштай хэрэгжүүлнэ.

НҮБ-ын Суурин зохицуулагч асан Тапан Мишра
Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын нутаг. Баруун
тайгын цаатан хүүхдүүдийн хамт. © НҮБСЗГ



2.5 Үнэлгээ, сургамж

Монгол Улс дундаас дээш орлоготой улсын статустай болсон, түүний хөгжлийн төлөв зэргийг харгалзан НҮБ-ын Удирдлагын багийн зүгээс байгууллага хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх, инновацийг дэмжих, НҮБ-ын үнэлэмжийг дээшлүүлэх зэрэгт тулгуурлан дараах сургамж, зөвлөмжийг тодорхойлж байна. Үүнд:

НҮБ 2.0 (Бүтэц, үйл ажиллагааг шинэ шатанд гаргах НҮБ-ын санаачлага)-ийн тэргүүлэх чиглэлүүдтэй нийцүүлэх:

“Өөрчлөлтийн таван элемент (Quintet of Change)” болох тоон мэдээлэл, цахим шилжилт, инноваци, стратегийн алсын хараа, зан үйлийн шинжлэх ухаан зэргийг НҮБ-ын Удирдлагын баг үйл ажиллагаандаа уялдуулах нь чухал болохыг онцолж байна. Оролцоог хангасан үйл ажиллагаа нь, тухайлбал, “Байгаа онох/ Nailing it) сорилт нь байгууллага нэг бүрийн инноваци, хамтын ажиллагааны соёлыг төлөвшүүлэхэд туслах бөгөөд НҮБ 2.0-ийн хүлээлтийг хангахын тулд дотоод чадавхыг тасралтгүй хөгжүүлэх шаардлагатайг илэрхийлнэ.

ТХЗ хурдасгуурын тэргүүлэх чиглэлүүдэд дахин үнэлгээ хийх:

Дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн ТХЗ-ын өөрчлөлтүүдтэй илүү сайн уялдуулах шаардлагатайг хүлээн зөвшөөрч, НҮБ-ын Удирдлагын баг ТХЗ-ын 12 хурдасгуурын хүрээнд НҮБ-ын ТХХАХ-нд дахин үнэлгээ хийх үүрэг хүлээнэ. ТХЗ-ын санхүүжилтийн эдийн засгийн шинжилгээг сайжруулах, бүсчилсэн хөгжлийг дэмжих, зорилтот мэдээлэл цуглуулах, хэрэгжихүйц арга хэмжээ авах замаар залуучуудын хөдөлмөр эрхлэлт, чадавхыг сайжруулахад онцгой анхаарал хандуулна.

Хамтарсан хөтөлбөрүүдийг сайжруулах:

Өнөөгийн хэрэгжүүлж байгаа Хамтарсан ажлын төлөвлөгөөнд тусгайлсан Хамтарсан хөтөлбөр (JPs) байхгүй ч системийн хэмжээнд уялдаа холбоог бий болгох, хуваагдмал байдлыг багасгах, хамтран хөрөнгө нөөц татан төвлөрүүлэхийн тулд сайтар боловсруулсан Хамтарсан хөтөлбөр үнэ цэнэтэй болохыг НҮБ-ын Удирдлагын баг дахин сануулж байна. Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал, ногоон ажлын байр, хөдөөгийн эмэгтэйчүүдийн уур амьсгалын өөрчлөлтийг тэсвэрлэх чадавх зэрэг хамтарсан хөтөлбөрийн чиглэлийг тодорхойлсон. Хамтарсан хөтөлбөрийн үзэл баримтлалыг эцэслэн боловсруулах ажлыг түргэвчлэх шаардлагатай гэдэгт санал нэгдэв.

Түншлэлийн стратеги 2.0 –Дундаас дээш орлоготой улсын статустай нөхцөлд Монгол Улс дахь НҮБ-ын байр суурь

Монгол Улс дундаас дээш орлоготой улсын ангилалд багтаж буй тохиолдолд НҮБ-ын Удирдлагын баг байр сууриа дахин авч үзэх шаардлагатайг хэлэлцүүлгийн үеэр онцолж байв. Оролцогч талуудын дунд НҮБ-ыг зөвхөн хандивлагч, эсвэл өрсөлдөгч гэж үзэх буруу ойлголт байгаа нь НҮБ-ын удирдан зохион байгуулах болон өвөрмөц, мэргэшсэн чиг үүргийн талаар илүү тодорхой мэдээлэл өгөх шаардлагатайг харуулж байна. ТХЗ-тай уялдсан тогтвортой санхүүжилтийн шийдлүүдийг олохын тулд хувийн хэвшил, санхүүгийн байгууллагууд, бүс нутгийн оролцогч талуудтай хамтран ажиллах зэргээр уламжлалт хандивлагчдаас гадна илүү өргөн хүрээтэй түншлэлийг хөгжүүлэхийн чухлыг НҮБ-ын Удирдлагын баг онцлон тэмдэглэв.

Хөрөнгө татан төвлөрүүлэх, Өмнөд-Өмнөдийн хамтын ажиллагааг сайжруулах:

Нөхцөл байдлын дүн шинжилгээний үр дүнд үндэслэн Монгол Улсын ТХЗ-ын санхүүжилтийн дутагдаж буй хэрэгцээ хандивлагчдын хуваагдмал байдлаас шалтгаалан улам нэмэгдэх болсныг хэлэлцүүлэгт оролцогчид тэмдэглээд санхүүжилтийн шинэлэг арга хэрэгсэл шаардлагатай байгааг онцолсон. Өмнөд-Өмнөдийн хамтын ажиллагааны хүрээнд БНХАУ болон бусад дунд орлоготой орнуудтай хамтын ажиллагаагаа бэхжүүлэх нь гол боломж гэж тодорхойлсон. Үүний нэгэн адил санхүүгийн салбарын оролцогчид болон олон улсын хүмүүнлэгийн байгууллагуудыг хөгжлийн өргөн хүрээний хөтөлбөрт татан оролцуулахыг зөвлөж байсан.

Орон нутгийн түвшний оролцоо, оролцоог хангах:

Орон нутгийн түвшинд, ялангуяа уур амьсгалын өөрчлөлтийг сөрөн тэсвэрлэх чадавхыг бий болгох, амар амгалан, хүртээмжтэй хөгжилд чиглэсэн тасралтгүй хүчин чармайлт чухал болохыг онцлон тэмдэглэсэн. Залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, уугуул болон эмзэг бүлгийн хүн амын бүрийн бүтээлч оролцоог хангах нь НҮБ-ын хэнийг ч орхигдүүлэхгүй байх зорилтод нийцнэ.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч хатагтай Амина Ж. Мохамед монгол малчин айлд зочилсон юм. ©НҮБСЗГ

2.6 Санхүүжилт, хөрөнгийн татан төвлөрүүлэлт

2023-2027 онд хэрэгжүүлэх НҮБ-ын ТХХАХ-ний санхүүгийн тайлангаас харахад нийтдээ 224.6 сая ам.долларын санхүүжилт шаардлагатай байна. 2023-2024 онд ойролцоогоор 90.7 сая ам.долларын хөрөнгийг зарцуулжээ. 2025-2027 онд хэрэгжүүлэхээр татан төвлөрүүлсэн нийт санхүүжилт 40.8 сая ам.доллар, мөн ойролцоогоор 85.1 сая ам.долларын санхүүжилт одоогоор дутагдаж байгаа нь нийт хэрэгцээний 41.42 хувь болж байна.

Өнгөрсөн жилийн мөн үеийн зарцуулалттай харьцуулбал, 2023 онд 44,7 сая ам.долларын хөрөнгө зарцуулсан бол 2024 онд нийт зарцуулалт 46,1 сая ам.доллар болж өссөн байна. Ялангуяа, Тэргүүлэх чиглэл 2 (Ногоон хөгжил)–ийн зарцуулалтад хамгийн их өсөлт гарч, нийт өсөлт нэмэгдэхэд гол нөлөө үзүүлсэн. Харин Тэргүүлэх чиглэл 1 болон Тэргүүлэх чиглэл 3-ын зарцуулалт бага хэмжээгээр буурсан нь хөрөнгө оруулалтын чиглэл, хөрөнгө хуваарилалтын стратеги өөрчлөгдсөнтэй холбоотой байна. 2024 онд нийт гүйцэтгэл 87 хувь байгаа нь хуваарилагдсан хөрөнгийг үр дүнтэй ашиглаж буйн илэрхийлэл юм. Энэ нь хөрөнгийн сул зогсолт үгүй, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг идэвхтэй дэмжиж байгааг харуулж байна.

Үүнд үндэслэн дараах гурван дүгнэлт хийж болно. Нэгдүгээрт, Тэргүүлэх чиглэл 1 болон Тэргүүлэх чиглэл 3-ын аль алинд санхүүжилт ихээхэн дутагдалтай хэвээр бөгөөд Тэргүүлэх чиглэл 1-д нийт шаардагдах санхүүжилтийн 50-иас дээш хувь дутагдалтай

байх тул яаралтай арга хэмжээ авах шаардлагатай. Хоёрдугаарт, Тэргүүлэх чиглэл 2-ын санхүүжилт харьцангуй сайн хэдий ч 2025-2027 онд тогтвортой санхүүжилтийг хангах хүчин чармайлтаа үргэлжлүүлэх шаардлагатай. Гуравдугаарт, нийт зарцуулалт 2023-2024 онд өссөн хэдий ч тодорхой салбар дахь хөрөнгийн төвлөрөл нь цаашид хөрөнгийн тэнцвэртэй хуваарилалтын стратеги шаардлагатайг харуулж байна.

Энэ хүрээнд Засгийн газрын холбогдох байгууллагууд болон хөгжлийн түншүүдтэй хамтын ажиллагааг бэхжүүлэхэд анхаарч, ялангуяа Тэргүүлэх чиглэл 1 болон Тэргүүлэх чиглэл 3-т хөрөнгө татан төвлөрүүлэх нэмэлт стратеги боловсруулах хэрэгтэй. Шинээр хөрөнгө оруулалт татахын тулд амжилтын түүх, бодит үр дүнг идэвхтэй мэдээлэх шаардлагатай. Тэргүүлэх чиглэл 2-ын хувьд 2027 он хүртэл тогтвортой дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ одоогийн санхүүжилтийн түвшинг хэвээр хадгалахыг зорих шаардлагатай. Цаашлаад, тухайн жилийн санхүүгийн зарцуулалтыг чиг хандлагаар нь задлан харуулах нь цаашдын хөрөнгө хуваарилалтын үр өгөөж, тэгш байдал аль алиныг нь оновчтой болгоход чухал ач холбогдолтой.

НҮБ-ын ТХХАХ	МУҮҮ/ОЖСХ шаардлагатай	2023 Зарцуулалт	2024 Зарцуулалт	2025- 2027 Бэлэн	Дутуу (\$)	Дутуу (%)
Тэргүүлэх чиглэл 1 Хүний хөгжил	91,302,730	14,884,540	14,361,397	13,718,276	48,338,517	52.94%
Тэргүүлэх чиглэл 2 Ногоон хөгжил	100,724,045	22,770,188	25,278,821	21,778,663	30,896,373	30.67%
Тэргүүлэх чиглэл 3 Засаглал, хүний эрх	32,581,552	7,038,850	6,459,909	5,292,606	13,790,187	42.33%
Нийт	224,608,327	44,693,578	46,100,127	40,789,545	85,053,553	41.42%

Бүлэг 3: НҮБ-ын Удирдлагын багаас 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүд



Стратегийн тэргүүлэх чиглэл 1



Эрүүл мэнд

Нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээний төвүүдийг бэхжүүлж, бүх нийтийн эрүүл мэндийн хамралт, өндөр үр нөлөө бүхий арга хэмжээнүүдэд анхаарлаа хандуулах. Үүнд яаралтай тусламжийн хариу арга хэмжээг сайжруулах, жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх арга хэмжээ, сургалтыг уялдуулах, эх, нялхсын эндэгдлийн тандан судалгаа, хариу арга хэмжээний стандарт үйл ажиллагааны журам, бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, эх баригчдын мэдлэг, ур чадвар, дадлага туршлагыг дээшлүүлэх зэрэг хамаарна.



Боловсрол

Хүртээмжтэй, жендэрийн эрх тэгш байдлыг хангасан боловсролыг дэмжих, ур чадвар, насан туршийн боловсролын хөтөлбөрийг өргөжүүлэх, сургуулийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх, өсвөр үе, залуучуудад эрүүл мэндийн эерэг зан үйлийг төлөвшүүлэх, үйлчилгээнээс орхигдох эрсдэлтэй хүүхдүүдэд хүрч ажиллахад онцгой анхаарах.



Нийгмийн хамгаалал

Нийгмийн ажлын чадавхыг бэхжүүлэх, нийгмийн даатгалын шинэчлэлийг дэмжих, ОУХБ-ын 102-р конвенцийг соёрхон батлахыг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шилжин суурьшигчдын эмзэг байдлыг бууруулах. Тэгш, хүртээмжтэй эрчим хүчний шилжилтийг дэмжих, хэнийг ч орхигдуулахгүй байхын тулд эмзэг бүлгийн хүн амын нийгмийн хамгааллыг дэмжих.



Ус, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуй

Ус, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн салбарын зохицуулалт, санхүүжилт, загварчлалыг сайжруулах, Ус, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйн шинэлэг үйлчилгээ, арга туршлагыг турших.



Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх

Хүүхэд хамгаалал, кейс менежментийн тогтолцоог бэхжүүлэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль эрх зүйн шинэчлэлийг дэмжих, жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн хүмүүс, ялангуяа эмзэг нөхцөлд байгаа эмэгтэйчүүд, охидыг чадавхжуулах.



Хүнсний аюулгүй байдал

Үндэсний хэмжээнд хүнсний аюулгүй байдлын үнэлгээ хийж, Монгол Улсын Хүнсний тухай хууль болон Монгол Улсын Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуулиудын шинэчилсэн найруулгад дэмжлэг үзүүлж, нянгийн эсрэг эсэргүүцэл болон нянгийн эсрэг эмийн хэрэглээтэй холбоотой асуудалд онцгойлон анхаарах.

Стратегийн тэргүүлэх чиглэл 2



Уур амьсгалын өөрчлөлт

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн стресс, түүний дотор урьдчилан таамаглах боломжгүй цаг агаарын төлөв байдал, зуд, үер зэрэг байгалийн гамшигт үзэгдлийн давтамж, эрчим нэмэгдэж байгаагаас үүдэлтэй сорилтуудыг шийдвэрлэх.



Ногоон хөгжил

Ногоон, тэгш, хүртээмжтэй, тогтвортой өсөлтийн стратеги, тэр дундаа эдийн засгийг төрөлжүүлэх хүчин чармайлтыг дэмжих замаар Монгол Улсын нүүрсэнд тулгуурласан өсөлтөөс ангижрах.



Уур амьсгалын өөрчлөлтийг сөрөн тэсвэрлэх чадвар

Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэх үндэсний чадавхыг бэхжүүлж, эмзэг бүлгийн хүн ам, уур амьсгалын өөрчлөлтөөс дайжсан шилжин суурьшигчдын уур амьсгалын өөрчлөлтийг сөрөн тэсвэрлэх чадварыг сайжруулах.



Тэгш, хүртээмжтэй эрчим хүчний шилжилт

Нүүрстөрөгчийн ялгаруулалтыг бууруулах замаар тэгш, хүртээмжтэй эрчим хүчний шилжилтийг дэмжих, Уур амьсгалын ҮТХН 3.0-д нийцсэн тогтвортой, хямд, ногоон эрчим хүчний шийдлүүдийг дэмжих, уур амьсгалд нийцэлтэй ухаалаг шийдлүүд бүхий нийгмийн үйлчилгээ үзүүлэх.



ҮТХН-ийн ахиулах шинэчилсэн зорилт

Монгол Улсын ҮТХН 3.0-ийн чанар, зорилтод жендэрийн асуудлыг тусгах замаар ахиулан тодорхойлохыг дэмжих. Мөн 2050 он гэхэд нүүрсхүчлийн хийг бүрэн саармагжуулахын тулд урт хугацааны нүүрсхүчлийн хий бага ялгаруулах хөгжлийн стратеги (LT-LEDS) боловсруулахад дэмжлэг үзүүлэх. Аж үйлдвэрийн бодлого, олон улсын худалдааны засаглал, эдийн засгийг төрөлжүүлэх зэрэг чиглэлээр хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог сайжруулах замаар засаглалыг бэхжүүлэх.



Нотолгоонд суурилсан Нийгмийн эрүүл мэндийн бодлого

Бодлого боловсруулах, богино болон урт хугацааны хөтөлбөрүүдийг боловсруулахад шаардагдах уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны бохирдлын нийгмийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг судлах, нотолгоог бий болгох, ашиглах үндэсний чадавхыг бэхжүүлэх.



Залуучууд, шилжин суурьшигчид

Жендэрийн мэдрэмжтэй технологи дамжуулалт, инновац, хөрөнгө оруулалтыг дэмжих, кластераар хөгжүүлэх арга хандлагд тулгуурлан бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх хувийн хэвшлийн стратегитай залуучууд болон шилжин суурьшигчдад чиглэсэн зорилтот арга хэмжээг уялдуулах.



Түншлэл

Тогтвортой, ногоон, хариуцлагатай өсөлтийн бат бөх суурь, хамтын ойлголцлыг бий болгохын тулд мэдлэгийн менежментийн стратегийг ашиглан салбар, байгууллагуудын хамтын ажиллагаа, түншлэлийг дэмжих.



Нэмүү өртөг

Сүү, сүүн бүтээгдэхүүн, хүнсний ногоо, мах, ноолуур, ноосны үйлдвэрлэлийг сайжруулж, эдгээр салбарт нэмүү өртөг шингээх төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих.



Тогтвортой газар нутгийн менежмент


15 сая га талбай нутаг дэвсгэр бүхий аймаг, сумдын нутаг дэвсгэрийн тогтвортой менежментийн төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлэх.

Стратегийн тэргүүлэх чиглэл 3



Хөгжлийн санхүүжилт

ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд хувийн хөрөнгө оруулалтыг татахын тулд ногоон бонд, холимог санхүүжилт зэрэг санхүүжилтийн шинэлэг шийдлүүдийг судалж, хэрэгжүүлэх




Институцийн чадавхыг бэхжүүлэх

Жендэрийн мэдрэмжтэй бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ хийх институцийн чадавхыг бэхжүүлэх, Монгол Улсад жендэрийн тэгш байдлыг хангах, жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэхэд хувь нэмэр оруулах.



Түншлэлийг дэмжих

Тогтвортой хөгжлийн санаачилгад хөрөнгө нөөц, туршлага хуримтлуулахын тулд засгийн газар, бизнес эрхлэгчид болон олон улсын байгууллагуудын түншлэлийг бэхжүүлэх.



Жендэрийн тэгш байдал

Уур амьсгалтын өөрчлөлттэй тэмцэх үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн манлайлал, бэлэн байдлыг сайжруулах, Монгол Улс дахь жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх хариу арга хэмжээний механизмыг сайжруулах замаар жендэрийн тэгш байдлыг хангах.



Цахим шилжилт

Хиймэл оюуныг сурталчилж, тэгш, хүртээмжтэй, хямд мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц, Хиймэл оюуныг боловсролын салбарт ашиглах, насан туршийн боловсролын боломжууд, дээд боловсролыг цахим болгох, хэвлэл мэдээллийн байгууллагын институцийн чадавхыг бэхжүүлэх.



Залуучуудын хөгжил

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг шинэчлэн боловсруулахад залуучууд, ИНБ зэрэг гол оролцогч талуудтай хамтран ажиллах чиглэлээр Засгийн газарт дэмжлэг үзүүлэх.



Хүний эрхийг хамгаалах

Хүний эрхийн зөрчлийг үр дүнтэй хянах, мэдээлэх, шийдвэрлэх эрх зүйн орчин, хүний эрхийн механизмыг бэхжүүлэх.



Залуучуудын асуудлаарх бодлогын хэрэгжилтэд хяналт тавих

Залуучуудын асуудлаарх бодлого, хөтөлбөрт хяналт шинжилгээ хийх арга хэрэгслийг боловсруулах, залуучуудын манлайлсан байгууллага, залуучууд өөрсдөө залуучуудын асуудлаарх бодлого, хөтөлбөрт хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, улмаар сайжруулах талаар сурталчлах талаарх Засгийн газрын хүчин чармайлтыг дэмжих.



Эрх зүйт ёс

Мөнгө угаах, авлига, хүн худалдаалах зэрэг зохион байгуулалттай гэмт хэргүүдтэй тэмцэх, хууль сахиулах байгууллагын чадавхыг чадавхыг дээшлүүлэх, аюулгүй байдлыг бэхжүүлэх.



Нотолгоонд суурилсан бодлого боловсруулах

Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа (SISS)-нд хоёрдогч дүн шинжилгээ хийх, хүн амын завсрын тооллогыг дэмжих, ГБХНХЯ-ны дэргэд Хүн ам, хөгжлийн бодлого судлалын төв байгуулахад дэмжлэг үзүүлэх



Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх

Хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх эрсдэлтэй хүмүүст чиглэсэн урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг эрчимжүүлж, ийм гэмт хэргийн хохирогчдын эрүүл мэнд, аюулгүй байдал, аж байдлыг сайжруулахад хувь нэмэр оруулах.

Товчилсон үгийн тайлбар

АН	Ардчилсан Нам
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БҮАС	Бизнесийн үйл ажиллагааны стратеги
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЖСХ	Жендэрт суурилсан хүчирхийлэл
МАН	Монгол Ардын Нам
МҮХАҮТ	Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБ-ын АҮХБ	НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллага
НҮБ-ын АНДЭЗНК	НҮБ-ын Ази Номхон далайн Эдийн засаг нийгмийн комисс
НҮБ-ын АБА	НҮБ-ын Аюулгүй байдлын алба
НҮБ-ын БОХ	НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр
НҮБ-ын БШУСБ	НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага
НҮБ-ын ГЭБГ	НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газар
НҮБ-ДОХ-ын НХ	ДОХ-той тэмцэх НҮБ-ын Нэгдсэн хөтөлбөр
НҮБ-ын ДАЭДКГ	НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газар
НҮБ-Эмэгтэйчүүд	НҮБ-ын Жендэйн тэгш байдал ба Эмэгтэйчүүдийг чадавхжуулах байгууллага
НҮБ-ын МБГХТА	НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба
НҮБСЗГ	НҮБ-ын Суурин зохицуулагчийн газар
НҮБХХААБ	НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн газар
НҮБ-ын ХХБХ	Худалдаа хөгжлийн бага хурал
НҮБХХ	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр
НҮБ-ын ХАС	НҮБ-ын Хүн амын сан
НҮБ-ын ХАБИТАТ	НҮБ-ын Хүн амын нутагшил суурьшлын хөтөлбөр
НҮБ-ын ХС	НҮБ-ын Хүүхдийн Сан
НҮБ-ын ТҮА	Төслийн үйлчилгээний алба
НҮБ-ын СДХ	НҮБ-ын Сайн дурынхны хөтөлбөр
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ОУХААХС	Олон улсын хөдөө аж ахуйн хөгжлийн сан
ОУХТ	Олон улсын худалдааны төв

ОУЦХБ	Олон улсын цахилгаан холбооны байгууллага
ОУШХБ	Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
ТХХАХ	Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ
УИХ	Улсын Их Хурал
ХҮН	ХҮН нам
ХХВ	Хүний хөхөнцөр вирус
ХХИ	Хүний хөгжлийн индекс
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ЦЗХИ	Цахим засаглалын хөгжлийн индекс
ШИМТ	Шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик

НҮБ-ын байр, Нэгдсэн Үндэстний гудамж-14,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот 14201,
Монгол Улс

Утас: (976-11) 327585



/unmongolia



@unmongolia

Вебсайт: mongolia.un.org